

Агуулга

Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал3

I. Нийгмийн үзүүлэлт 6

1. Бүртгэлтэй ажилгүй иргэн 6
- Ажлын шинэ байр
2. Өрхийн орлого, зарлага 6
3. Хүн амын амьжиргааны байдал 8
4. Нийгмийн даатгал, халамж 9
5. Эрүүл мэнд 11
6. Гэмт хэрэг 13

II. Макро эдийн засгийн үзүүлэлт 15

1. Үнэ 15
2. Мөнгө, зээл, үнэт цаас 19
3. Улсын нэгдсэн төсөв..... 22
4. Төлбөрийн тэнцэл 23
5. Гадаад худалдаа 24

III. Үйлдвэрлэл, үйлчилгээ 27

1. Аж үйлдвэр 27
2. Тээвэр 28

IV. Бусад 31

1. Цаг уур, агаарын бохирдолт31

V. Хавсралт хүснэгтүүд 33

VI. Хүүхдийн хоол тэжээлийн хангамж ба эрүүл мэнд 46

VII. Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм 53

Дараах тэмдэглэлүүдийг ашиглав:

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй.



**Монгол Улсын нийгэм,
эдийн засгийн байдал**
(2011 оны эхний 11 сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт

Улсын хэмжээнд 2011 оны эхний 11 сард 64667 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 4007 эх буюу 6.6 хувь, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 64910 болж, 4037 хүүхэд буюу 6.6 хувиар өслөө.

Улсын хэмжээнд 2011 оны эхний 11 сард нэг хүртэлх насандаа 1055 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 120 хүүхэд буюу 10.2 хувь, 1-5 хүртэлх насны 231 хүүхэд эндэж, 86 хүүхэд буюу 27.1 хувиар буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2011 оны 11 дүгээр сарын эцэст 62.7 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 22.1 мянга хүнээр буюу 54.4 хувиар өсчээ.

Нийгмийн даатгалд 2011 оны эхний 11 сард 629.5 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 411.6 мянга буюу 65.4 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагынх, 217.9 мянга буюу 34.6 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 72.8 мянга буюу 13.1 хувь, үүнээс аж ахуйн нэгж байгууллагынх 68.9 мянга буюу 20.1 хувь, төсөвт байгууллагынх 3.8 мянга буюу 1.8 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2011 оны эхний 11 сард 56.8 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 1.1 мян.хүн буюу 2.0 хувь, олгосон тэтгэврийн хэмжээ 7.5 тэрбум төг буюу 30.2 хувиар нэмэгджээ.

“Хүний хөгжил” сангаас 2011 оны эхний 11 сард 666.8 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 2.7 сая иргэнд олгожээ.

Халдварт өвчнөөр 2011 оны эхний 11 сард 38.3 мян.хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 1598 хүн буюу 4.3 хувиар нэмэгдсэн нь гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчдийн тоо 1593 хүн буюу 61.7 хувь, мөөгөнцөр өвчнөөр өвчлөгчдийн тоо 2255 хүн буюу 56.5 хувь, цусан суулгаар өвчлөгчдийн тоо 1276 хүн буюу 38.5 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 543 хүн буюу 12.7 хувь, гонококкт халдвараар

өвчлөгчдийн тоо 397 хүн буюу 7.7 хувь, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 186 хүн буюу 4.7 хувиар буурсан хэдий ч вирүст гепатитаар өвчлөгчдийн тоо 5698 хүн буюу 82.4 хувь, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 1786 хүн буюу 2.7 дахин, гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 380 хүн буюу 74.4 хувь, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 354 хүн буюу 9.9 хувиар нэмэгдсэнээс голлон шалтгаалав.

Улсын хэмжээнд 2011 оны эхний 11 сард 17591 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 342 хэргээр буюу 1.9 хувиар буурчээ. Үүнд өмнөх оны мөн үеийнхээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг (269), нийгмийн аюулгүй байдлын эсрэг (206), захиргааны журмын эсрэг (44), шүүн таслах ажиллагааны эсрэг (35), хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг (33) зэрэг гэмт хэрэг нэмэгдсэн хэдий ч өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (609), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (237), хүн амын эрүүл мэндийн эсрэг (58) зэрэг гэмт хэрэг буурсан нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2011 оны эхний 11 сард 7294 хүн гэмтэж, 871 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 900 буюу 14.1 хувиар өсч, нас барсан хүний тоо 318 буюу 26.7 хувиар буурсан байна.

II. Макро эдийн засгийн үзүүлэлт

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮҮИ) 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 1.3 хувь, 2010 оны 12 дугаар сарынхаас 8.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 10.8 хувиар өслөө. Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дүн 2.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 2.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2011 оны 11 дүгээр сарын эцэст 6133.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 45.4 тэрбум төг буюу 0.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2194.1 тэрбум төг буюу 55.7 хувиар өсчээ.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2011 оны 11 дүгээр сарын эцэст 678.9 тэрбум төг болж,



өмнөх сарынхаас 16.0 тэрбум төг буюу 2.3 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 206.0 тэрбум төг буюу 43.6 хувиар өсчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2011 оны 11 дүгээр сарын эцэст 5438.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 216.8 тэрбум төг буюу 4.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2326.2 тэрбум төг буюу 74.7 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2011 оны 11 дүгээр сарын эцэст 71.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 0.5 тэрбум төг буюу 0.7 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 18.7 тэрбум төг буюу 20.7 хувиар буурчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2011 оны 11 дүгээр сарын эцэст 343.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 4.2 тэрбум төг буюу 1.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 27.7 тэрбум төг буюу 7.5 хувиар буурсан байна.

Үнэт цаасны арилжаа 2011 оны 11 дүгээр сард 22 өдөр явагдаж, 34.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 10.1 сая ш үнэт цаас арилжигдсан байна.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2011 оны 11 дүгээр сард 21148.7 болж, өмнөх сарынхаас 486.7 нэгжээр өсчээ.

Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2011 оны эхний 11 сард 3860.2 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 3813.3 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн нийт тэнцэл 46.9 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Нэгдсэн төсвийн ашиг 2011 оны эхний 10 сарынхаас 142.8 тэрбум төг буюу 75.3 хувиар багассан байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцэл өмнөх оны мөн үеийнхээс 24.1 тэрбум төгрөгөөр буурахад орлогын өсөлт нь зарлагын өсөлтөөс 2.3 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Төсвийн урсгал орлого 3705.2 тэрбум төг, урсгал зардал 2776.6 тэрбум төг болж, урсгал тэнцэл 928.6 тэрбум төгрөгийн ашигтай гарав.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 978.4 тэрбум төг буюу 42.2 хувиар

нэмэгдэхэд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн орлогын албан татвар 318.3 тэрбум төг буюу 85.1 хувиар буурсан хэдий ч дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 521.1 тэрбум төг буюу 68.8 хувь, бусад татварын орлого 309.7 тэрбум төг буюу 2.2 дахин, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 151.8 тэрбум төг буюу 44.8 хувь, гадаад худалдааны татварын орлого 130.7 тэрбум төг буюу 77.4 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 116.6 тэрбум төг буюу 42.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 124.0 тэрбум төг буюу 43.9 хувиар өсөхөд төсөвт газрын өөрийн орлого 57.2 тэрбум төг буюу 46.5 хувь, хувьцааны ногдол ашгийн орлого 26.9 тэрбум төг буюу 2.9 дахин, газрын тосны орлого 17.5 тэрбум төг буюу 39.8 хувь, хүү, торгуулийн орлого 17.3 тэрбум төг буюу 76.2 хувь, навигацын орлого 2.5 тэрбум төг буюу 7.0 хувь, бусад нэр заагдаагүй орлого 2.3 тэрбум төг буюу 5.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2011 оны эхний 11 сард 3813.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1241.1 тэрбум төг буюу 48.3 хувиар нэмэгдсэн нь зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 6.0 тэрбум төг буюу 14.9 хувиар буурсан хэдий ч татаас, шилжүүлгийн зардал 577.1 тэрбум төг буюу 63.7 хувь, хөрөнгийн зардал 334.4 тэрбум төг буюу 80.7 хувь, бараа, үйлчилгээний зардал 271.2 тэрбум төг буюу 27.5 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 63.9 тэрбум төг буюу 28.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хөрөнгийн зардалд 2011 оны эхний 11 сард 749.0 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 334.4 тэрбум төг буюу 80.7 хувиар нэмэгджээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс дотоодын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 300.0 тэрбум төг буюу 74.5 хувь, гадаад эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 34.4 тэрбум төг буюу 3.9 дахин өссөнөөс шалтгаалжээ.

Манай улс 2011 оны эхний 11 сард дэлхийн 123 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 10271.2 сая



ам.долл, үүнээс экспорт 4303.9 сая ам.долл, импорт 5967.3 сая ам.долларт хүрчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны эхний 11 сард 1663.4 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 1343.0 сая ам.долл буюу 5.2 дахин өсчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2010 оны 11 дүгээр сард 62.5 сая ам.долларын алдагдалтай гарсан бол 2011 оны 11 дүгээр сард 99.7 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 37.2 сая ам.долл буюу 59.5 хувиар өсчээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 4849.4 сая ам.долл буюу 89.4 хувь, үүнээс импортын хэмжээ 3096.2 сая ам.долл буюу 2.1 дахин, экспортын хэмжээ 1753.2 сая ам.долл буюу 68.7 хувиар өсчээ.

III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2011 оны эхний 11 сард 1860.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 175.4 тэрбум төг буюу 10.4 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд газрын тос, нүүрс, төмрийн хүдэр зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 12.1 хувиас 2.3 дахин, нарийн боов, адууны мах, сүлжмэл эдлэл, самнасан ноолуур, талх, амтат ус, ундаа, шингэн сүү, архи, жүүс, шар айраг, цэвэр ус, бетон зуурмаг зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.3-79.9 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Төмөр замын тээврээр 2011 оны эхний 11 сард 16783.2 мян.т ачаа, давхардсан тоогоор 3540.0 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1500.6 мян.т буюу 9.8 хувь, зорчигчдын тоо 300.5 мян.хүн буюу 9.3 хувиар өсчээ. Төмөр замын тээврийн салбарын орлого 2011 оны эхний 11 сард 354.1 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 82.6 тэрбум төг буюу 30.4 хувиар өсчээ.

Агаарын тээврээр 2011 оны эхний 11 сард 2.6 мян.т ачаа, давхардсан тоогоор 525.5 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1.1 мян.т буюу 71.5

хувь, зорчигчдын тоо 160.8 мян.хүн буюу 44.1 хувиар өсчээ. Агаарын тээврийн салбарын орлого 2011 оны эхний 11 сард 149.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 44.2 тэрбум төг буюу 41.8 хувиар нэмэгджээ.

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2011 оны 11 дүгээр сард Дорнод аймгийн Чойбалсан суманд (24.9 мм) орсон байна. Энэ оны 11 дүгээр сард Өмнөговь аймгийн Ханбогд суманд хамгийн их дулаан буюу +13.1 хэм, Завхан аймгийн Тосонцэнгэл суманд хамгийн хүйтэн буюу -36.4 хэм байлаа. Салхины хурд Говь-Алтай аймгийн Цогт суманд 18 м/с хүрчээ.

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2011 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 30 удаа, Баруун дөрвөн замын орчимд 28 удаа, Хархорин захын орчимд 23 удаа, Мишээл экспо төв, 32-ын тойрог орчимд тус бүр 22 удаа, 1-р хороолол орчимд 16 удаа, Офицеруудын ордон орчимд 5 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 13-р хороолол, 32-ын тойрог орчимд тус бүр 28 удаа, Баруун дөрвөн замын орчимд 26 удаа, Мишээл экспо төвийн орчимд 22 удаа, Офицеруудын ордон орчимд 18 удаа, 1-р хороолол орчимд 17 удаа, Хархорин захын орчимд 14 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 32-ын тойрог орчимд 26 удаа, 13-р хороолол орчимд 21 удаа, Баруун дөрвөн зам, Мишээл экспо төвийн орчимд тус бүр 15 удаа, Хархорин захын орчимд 9 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн замын орчимд 26 удаа 13-р хороолол орчимд 24 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

Аюулт үзэгдэл, осол 2011 оны эхний 11 сард 3268 удаа гарсны улмаас 202 хүн амь насаа алдаж, 165.5 мян.толгой мал, тэжээвэр амьтан хорогджээ. Энэ оны эхний 11 сард объектын түймэр 2802 удаа, бичил уурхай, нурангины осол 20 удаа, мал, тэжээвэр амьтны галзуу өвчин 39 удаа, гол, нуурын усанд унасан осол 92 удаа бүртгэгджээ. Энэ оны эхний 11 сард аюулт үзэгдэл, ослын улмаас 5.0 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.



I. Нийгмийн үзүүлэлтүүд

I.2 1. Бүртгэлтэй ажилгүй иргэн*

Зураг-I.1

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоог өмнө нь аймаг, нийслэлийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдээр гаргаж байсан бол 2011 оны 11 сараас эхлэн шинэчилсэн маягтын дагуу аймаг, нийслэлийн хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдээс гадна хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөр зуучлалын хувийн албадад бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоогоор гаргадаг боллоо. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2011 оны 11 дүгээр сарын эцэст 62.7 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 22.1 мянга хүнээр буюу 54.4 хувиар өсчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 28.7 мянга буюу 45.7 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 6.9 пунктээр буурчээ. Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 36.0 мянга буюу 57.4 хувь нь 16-34 насны залуучууд байгаа бөгөөд энэ үзүүлэлт Дархан-Уул, Төв, Дундговь, Хэнтий, Өмнөговь, Баянхонгор, Сэлэнгэ, Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Орхон, Сүхбаатар аймагт улсын дунджаас 0.7-20.3 пунктээр дээгүүр байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1.0 хувь нь магистр, доктор, 20.8 хувь нь дипломын болон бакалаврын, 7.0 хувь тусгай мэргэжлийн дунд, 7.1 хувь нь техникийн болон мэргэжлийн, 46.6 хувь нь бүрэн дунд, 13.2 хувь нь суурь, 3.4 хувь нь бага, 0.9 хувь нь боловсролгүй иргэд байна (Зураг I.1).


Ажлын шинэ байр *

2011 оны эхний 11 сард 68.1 мянган ажлын шинэ байр бий болжээ. Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн 29.6 мянга буюу 43.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажлын шинэ байрыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 18.5 хувь нь барилгын салбарт, 17.4 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын, 12.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 12.0 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны, 11.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 10.4 хувь нь уул уурхай, олборлолтын, 3.2 хувь нь боловсролын, 14.7 хувь нь бусад салбарт ногдож байна (Зураг I.2).

Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг насны ангиллаар авч үзвэл 21.7 хувь буюу 14.8 мянга нь 15-24, 32.9 хувь буюу 22.4 мянга нь 25-34, 24.7 хувь буюу 16.8 мянга нь 35-44, 19.2 хувь буюу 13.0 мянга нь 45-59, 1.5 хувь буюу 1.1 мянга нь 60, түүнээс дээш насны хүмүүс байна.(Зураг I.3).

Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг ажил мэргэжлийн ангиллаар

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2011 оны 11 дүгээр сарын эцэст, хувиар




Зураг-I.2

Ажлын шинэ байранд ажилд орсон хүний тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2011 оны эхний 11 сарын байдлаар



Зураг-I.3

Ажлын шинэ байранд ажилд орсон хүний тоо, насны бүлгээр, 2011 оны эхний 11 сарын байдлаар



авч үзвэл 3.0 хувь нь менежерийн, 9.9 хувь нь мэргэжилтэн, 2.6 хувь нь техникч болон туслах мэргэжилтэн, 2.2 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 16.3 хувь нь худалдаа үйлчилгээний ажилтан, 14.8 хувь нь хөдөө аж ахуй, загас агнуурын ажилтан, 22.5 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын холбогдох үйлчилгээний ажилтан, 7.4 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 21.1 хувь нь энгийн ажил мэргэжил, 0.2 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжилтэй хүмүүс байна.

* - Эх үүсвэр: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны 2011 оны 11 дүгээр сарын мэдээгээр




I.2 Өрхийн орлого, зарлага

Зураг-I.4

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2011 оны 3 дугаар улирлын судалгааны дүнгээр нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 513.5 мян.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 88.4 мян.төг буюу 20.8 хувиар нэмэгдлээ. Үүнд хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 12.0 мян.төг буюу 16.5 хувиар буурсан хэдий ч тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговрын орлого 54.3 мян.төг буюу 86.3 хувиар, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 15.3 мян.төг буюу 40.0 хувиар, цалин, хөлсний орлого 33.5 мян.төг буюу 16.7 хувиар өссөн нь нөлөөллөө.


Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар, хувиар



2011 VII-IX

НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар

Орлогын төрөл	2010 VII-IX	2011 VII-IX	2011 VII-IX 2010 VII-IX %
Мөнгөн орлого - Бүгд	425 166.2	513 544.5	120.8
Цалин, хөлс	201 173.4	234 684.7	116.7
Тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор	62 923.7	117 224.8*	186.3
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого	38 224.4	53 497.1	140.0
Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	72 776.7	60 804.4	83.5
Бусад орлого	50 068.0	47 333.5	94.5



Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтцийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговрын орлогынх 8.0 пункт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлогынх 1.4 пунктээр нэмэгдэж, харин цалин, хөлсний орлогынх 1.6 пункт, бусад орлогынх 2.6 пункт, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлогынх 5.2 пунктээр буурчээ (Зураг I.4).

Хэрэглээний үнийн индексээр засварлан тооцвол нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээ 2011 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс 9.3 хувиар өслөө. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2011 оны 3 дугаар улирлын байдлаар 501.9 мян.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 36.6 мян.төг буюу 7.9 хувиар өссөн байна.

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 36.6 мян.төг буюу 7.9 хувиар нэмэгдэхэд хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага 30.8 мян.төг буюу 11.0 хувиар (үүнээс тээврийн зарлага 7.9 мян.төг буюу 21.3 хувь, холбооны зарлага 2.6 мян.төг буюу 12.8 хувиар), хүнсний бүтээгдэхүүний зарлага 4.6 мян.төг буюу 2.7 хувь (үүнээс мах, махан бүтээгдэхүүний зарлага 15.1 мян.төг буюу 34.0 хувиар) өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индексээр засварлан тооцвол нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2011 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс 2.4 хувиар буурсан байна.




**НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА,
жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар**

Зураг-1.5

Зарлагын төрөл	2010 VII-IX	2011 VII-IX	төг
			2011 VII-IX 2010 VII-IX%
Мөнгөн зарлага - Бүгд	465 366.8	501 934.3	107.9
1. Хүнсний бүтээгдэхүүний зарлага	174 975.6	179 614.1	102.7
Үүнээс:			
Мах, махан бүтээгдэхүүн	44 377.5	59 480.2	134.0
Гурил, гурилан бүтээгдэхүүн	41 348.7	43 982.6	106.4
2. Хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага	278 933.4	309 755.1	111.0
Үүнээс:			
Тээвэр	37 080.9	44 992.0	121.3
Холбоо	20 150.7	22 728.8	112.8
3. Бусдад өгсөн бэлэг, тусламж	11 457.8	12 565.1	109.7

**Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц,
жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар, хувиар**



Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтцийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2011 оны 3 дугаар улиралд хүнсний бус бараа үйлчилгээний болон бусад зарлага 1.8 пунктээр нэмэгдэж, харин хүнсний бүтээгдэхүүний зарлага 1.8 пунктээр буурчээ (Зураг 1.5).

1.3 Хүн амын амьжиргааны байдал

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2011 оны 3 дугаар улирлын судалгааны дүнгээр жишсэн нэг хүнд сард ногдох дундаж орлогыг тооцож, 2011 оны эхний 9 сарын хэрэглээний үнийн индексээр засварлан нэг хүнд ногдох сарын дундаж орлогыг тодорхойлов.

Нэг хүнд ногдох сарын дундаж орлогын хэмжээ (хэрэглээний үнийн индексээр засварласан) амьжиргааны доод түвшнээс Хангайн бүсэд 10.8 хувь, Баруун бүсэд 18.9 хувь, Зүүн бүсэд 38.6 хувь, Төвийн бүсэд 45.1 хувь, Улаанбаатар хотод 53.6 хувь, улсын дунджаар 32.8 хувиар их байна.

Хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг тодорхойлох Жини коэффициент 2011 оны 3 дугаар улиралд улсын дунджаар 0.370 байгаа бөгөөд хүн амын хэрэглээний тэгш бус байдал Улаанбаатар хотод 0.416 байгаа нь улсын дунджаас 0.046 нэгжээр их, бусад бүсэд улсын дунджаас 0.082-0.01 нэгжээр бага байна.


Орлогын ялгаатай бүлгүүдийн хувьд тэгш бус байдлыг илэрхийлэх тухайн бүлэг доторх болон бүлэг хоорондох тэгш бус

**Нэг хүнд ногдох сарын дундаж орлого,
амьжиргааны доод түвшинтэй харьцуулснаар, бүсээр**

	Хүн амын амьжиргааны доод түвшин (АДТ) (2011 оны 4 сарын 1-нээс мөрдсөн), төг	Нэг хүнд ногдох сарын дундаж (хэрэглээний үнийн индексээр засварласан) орлого (ДО), 2011 оны 3 дугаар улирлын байдлаар, төг	ДО / АДТ %
Улсын дундаж	110 500	146 763	132.8
Баруун	104 300	124 005	118.9
Хангай	105 100	116 434	110.8
Төв	106 600	154 668	145.1
Зүүн	103 500	143 426	138.6
Улаанбаатар	118 100	181 404	153.6

Зураг-1.6

**Нэг хүнд ногдох сарын дундаж орлого,
амьжиргааны доод түвшин, бүсээр,
2011 оны 3 дугаар улирлын байдлаар**





байдлыг харуулах Тейлийн индекс 2011 оны 3 дугаар улиралд 0.322 байна.

Тэгш бус байдлыг тодорхойлох өөр нэг үндсэн үзүүлэлт нь хүн амыг хэрэглээний түвшингээр нь тэнцүү 5 бүлэгт хуваах арга юм. Энэ нь хүн амыг нэг хүнд ногдох хэрэглээний хэмжээгээр нь ядуугаас чинээлэг рүү нь эрэмбэлэн, 20, 20 хувиар буюу тэнцүү 5 бүлэгт хувааж, тухайн бүлэг тус бүрийн дундаж хэрэглээний нийт хэрэглээнд эзэлж буй хувийг тооцож гаргана.

Улсын хэмжээнд хамгийн бага хэрэглээтэй бүлэг нийт хэрэглээний 7.6 хувийг эзэлж байхад хамгийн чинээлэг хэсгийнх 43.8 хувь байна. Энэ нь хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхны хэрэглээний дундаж хэмжээ 2011 оны 3 дугаар улиралд ядуу 20 хувийнхнаас 5.8 дахин их байгааг харуулж байна. Хамгийн чинээлэг хэсгийн хэрэглээний дундаж хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 1.2 пунктээр буурсан бол хамгийн ядуу хүний хэрэглээ 0.5 пунктээр нэмэгдсэн байна.

Хүн амын нийт хэрэглээнд хамгийн чинээлэг бүлгийн эзлэх хувь улсын дунджаас Улаанбаатар хотод 5.1 пунктээр их, Төв, Зүүн, Хангай, Баруун бүсүүдийн хувьд 0.4-5.8 пунктээр бага байна. Түүнчлэн Улаанбаатар, Төв, Зүүн бүсэд хамгийн бага хэрэглээтэй бүлгийн нийт хэрэглээнд эзлэх хувь улсын дунджаас доогуур байна.

I.4 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал:

Нийгмийн даатгалын сангийн орлого 2011 оны эхний 11 сард 637.3 тэрбум төг, зарлага 544.8 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 118.9 тэрбум төг буюу 22.9 хувь, зарлага 74.6 тэрбум төг буюу 15.9 хувиар нэмэгдлээ.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2011 оны эхний 11 сард өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдэхэд ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 12.3 тэрбум төг буюу 50.3 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 7.3 тэрбум төг буюу 44.3 хувиар, тэтгэврийн даатгалын сангийн орлого 82.9 тэрбум төг буюу 22.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Тэгш бус байдлын хэмжигдэхүүн, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар, бүсээр


	Жини коэффициент		Тейлийн индекс	
	2010 VII-IX	2011 VII-IX	2010 VII-IX	2011 VII-IX
Улсын дундаж	0.378	0.370	0.286	0.322
Баруун	0.349	0.288	0.242	0.146
Хангай	0.357	0.300	0.285	0.161
Төв	0.410	0.360	0.314	0.223
Зүүн	0.293	0.348	0.141	0.264
Улаанбаатар	0.391	0.416	0.305	0.476

Нийт хэрэглээнд хүн амын тооны тэнцүү 5 бүлэг тус бүрийн хэрэглээний эзлэх хувь, бүсээр, 2011 оны 3 дугаар улирлын байдлаар

	Нийт хэрэглээ	5 бүлэг				
		I (Хамгийн ядуу)	II	III	IV	V (Чинээлэг)
Улсын дундаж	100.0	7.6	11.8	15.6	21.2	43.8
Баруун	100.0	8.9	13.7	17.0	22.4	38.0
Хангай	100.0	9.0	12.9	16.7	22.1	39.3
Төв	100.0	7.0	11.3	16.0	22.3	43.4
Зүүн	100.0	7.5	12.5	15.9	21.4	42.7
Улаанбаатар	100.0	6.7	10.5	14.1	19.8	48.9

Зураг-1.7

Нэг хүнд ногдох хэрэглээ, улсын дунджаар, хүн амын тооны тэнцүү 5 бүлгээр, 2011 оны 3 дугаар улирлын байдлаар



Нийгмийн даатгалын сангийн зарлага нэмэгдэхэд эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 8.6 тэрбум төг буюу 9.9 хувиар буурсан хэдий ч, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 5.5 тэрбум төг буюу 24.7 хувь, тэтгэврийн даатгалын сангийн зарлага 79.5 тэрбум төг буюу 23.9 хувиар өссөн нь нөлөөлөв.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2011 оны эхний 11 сард 402.8 тэрбум төг болсны 74.5 хувийг өндөр настны, 12.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 6.4 хувийг тэжээгчээ алдсаны, 6.9 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад




өндөр настны тэтгэвэр 26.3 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэтгэвэр 21.0 хувь, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 12.4 хувь, цэргийн тэтгэвэр 28.3 хувиар өсчээ. (Зураг 1.8).

Нийгмийн даатгалд 2011 оны эхний 11 сард 629.5 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 411.6 мянга буюу 65.4 хувь нь аж ахуйн нэгж байгууллагынх, 217.9 мянга буюу 34.6 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 72.8 мянга буюу 13.1 хувь, үүнээс аж ахуйн нэгж байгууллагынх 68.9 мянга буюу 20.1 хувь, төсөвт байгууллагынх 3.8 мянга буюу 1.8 хувиар нэмэгджээ.

Зураг-1.8

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн бүтэц, 2011 оны эхний 11 сарын байдлаар, хувиар




Нийгмийн халамж:

Нийгмийн халамжийн сангаас 2011 оны эхний 11 сард 174.5 мян.хүнд 61.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 2.0 мян. хүн буюу 1.1 хувиар буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 15.8 тэрбум төг буюу 34.6 хувиар өсчээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын 48.8 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, 32.6 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 9.0 хувь нь ахмад настныг асарч буй иргэд, 8.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 1.1 хувь нь бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөж буй иргэд байна. (Зураг 1.9).

Зураг-1.9


Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын бүтэц, 2011 оны эхний 11 сарын байдлаар, хувиар



Нийгмийн халамжийн сангаас 2011 оны эхний 11 сард олгосон нийт тэтгэвэр, тэтгэмжийн 32.3 тэрбум төг буюу 52.7 хувийг халамжийн тэтгэвэрт, 18.9 тэрбум төг буюу 30.9 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 4.7 тэрбум төг буюу 7.7 хувийг ахмад настныг асарч буй иргэдэд, 4.7 тэрбум төг буюу 7.6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асарч буй иргэдэд, 659.4 сая төг буюу 1.1 хувийг бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжид зарцуулсан байна.(Зураг 1.10).

Зураг-1.10

Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц, 2011 оны эхний 11 сарын байдлаар, хувиар



Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2011 оны эхний 11 сард 56.8 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 1.1 мян.хүн буюу 2.0 хувь, олгосон тэтгэврийн хэмжээ 7.5 тэрбум төг буюу 30.2 хувиар нэмэгджээ.



Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 379.2 мян.хүн хамрагдсаны 27.3 хувь нь ахмад настан, 1.2 хувь нь алдар цолтой ахмад настан, 11.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 54.1 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 6.4 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд байна.

1.5 Эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2011 оны эхний 11 сард 64667 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 4007 эх буюу 6.6 хувь, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 64910 болж, 4037 хүүхэд буюу 6.6 хувиар өслөө (Зураг 1.11). Энэ оны 11 дүгээр сард 6013 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 593 хүүхэд буюу 10.9 хувиар нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2011 оны эхний 11 сард нэг хүртэлх насандаа 1055 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 120 хүүхэд буюу 10.2 хувь, 1-5 хүртэлх насны 231 хүүхэд эндэж, 86 хүүхэд буюу 27.1 хувиар буурчээ (Зураг 1.12). Энэ оны эхний 11 сард жирэмслэлт болон төрөлтийн улмаас 29 эх эндсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4 эх буюу 16.0 хувиар нэмэгдсэн байна.

Нэг хүртэлх насандаа 2011 оны 11 дүгээр сард 90 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 2 хүүхэд, 1-5 хүртэлх насандаа 19 хүүхэд эндэж, 6 хүүхдээр буурсан байна. Энэ оны 11 дүгээр сард 2 эх эндсэн байна.


1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2011 оны эхний 11 сард 16 болж, өмнөх оны мөн үеийнхээс 3 хүүхдээр буурсан бөгөөд энэ үзүүлэлт Хөвсгөл (30), Өвөрхангай (26), Төв (26), Увс (25), Говь-Алтай (24), Баян-Өлгий (22), Завхан (21), Өмнөговь (21) аймагт улсын дунджаас 5-14 хүүхдээр, Ховд (19), Баянхонгор (19), Дорнод (19), Сүхбаатар

Тайлбар: * Тав хүртэлх насны хүүхдэд 0-4 нас 364 хүртэл хоногтой хүүхдийг хамруулав.

Алдарт эхийн одонтой 178.7 мянган эхчүүдэд 2011 оны эхний 11 сард 28.5 тэрбум төгрөгийн тусламж олгосон байна.

“Хүний хөгжил” сангаас 2011 оны эхний 11 сард 666.8 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 2.7 сая иргэнд олгожээ.

Зураг-1.11



Зураг-1.12



(17), Хэнтий (18), Архангай (17) аймагт 1-3 хүүхдээр илүү байна.

1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насандаа* эндсэн хүүхдийн тоо энэ оны эхний 11 сард 20 болж, өмнөх оны мөн үеийнхээс 5 хүүхдээр буурчээ. Тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 2011 оны 11 дүгээр сард 109 болж, өмнөх оны мөн үеийнхээс 8 хүүхдээр буурсан байна.

Халдварт өвчнөөр 2011 оны эхний 11 сард 38.3 мян.хүн өвчилж, өмнөх оны мөн



үеийнхээс 1598 хүн буюу 4.3 хувиар нэмэгдсэн нь гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчдийн тоо 1593 хүн буюу 61.7 хувь, мөөгөнцөр өвчнөөр өвчлөгчдийн тоо 2255 хүн буюу 56.5 хувь, цусан суулгаар өвчлөгчдийн тоо 1276 хүн буюу 38.5 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 543 хүн буюу 12.7 хувь, гонококкт халдвараар өвчлөгчдийн тоо 397 хүн буюу 7.7 хувь, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 186 хүн буюу 4.7 хувиар буурсан хэдий ч вирүст хепатитаар өвчлөгчдийн тоо 5698 хүн буюу 82.4 хувь, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 1786 хүн буюу 2.7 дахин, гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 380 хүн буюу 74.4 хувь, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 354 хүн буюу 9.9 хувиар нэмэгдсэнээс голлон шалтгаалав.

Халдварт өвчнөөр 2011 оны 11 дүгээр сард 4980 хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 1033 хүн буюу 26.2 хувиар өсөхөд салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 61 хүн буюу 25.1 хувь, цусан суулгаар өвчлөгчдийн тоо 20 хүн буюу 13.4 хувь, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 20 буюу 7.8 хувиар буурсан хэдий ч вирүст хепатитаар өвчлөгчдийн тоо 455 хүн буюу 22.3 хувь, гонококкт халдвараар өвчлөгчдийн тоо 136 хүн буюу 35.3 хувь, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 115 хүн буюу 41.1 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

10 000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо улсын дунджаар 135 болж, өмнөх оны мөн үеийнхээс 3 хүнээр нэмэгдсэн байна (Зураг I.13).


Улаанбаатар хотод 2011 оны 11 дүгээр сард ХДХВ/ДОХ-ын 1 тохиолдол илэрч улсын хэмжээнд ХДХВ/ДОХ-ын нийт 99 тохиолдол бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2011 оны эхний 11 сард нийт 15724 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс 90 хүн буюу 0.6 хувиар буурчээ (Зураг I.14). Эмнэлэгт нас барсан хүний тоо энэ

Зураг-I.13



Зураг-I.14



оны эхний 11 сард 3854 болж, өмнөх оны мөн үеийнхээс 6 хүн буюу 0.2 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь нийт нас баралтын 24.5 хувийг эзэлж байна. Нас барсан хүний тоо 2011 оны 11 дүгээр сард 1424 болж, өмнөх оны мөн үеийнхээс 61 хүн буюу 4.5 хувиар нэмэгдэв.

Эмнэлэгт 2011 оны эхний 11 сард нийт 629.0 мян.хүн хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 9581 хүн буюу 1.5 хувиар нэмэгджээ. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2011 оны 11 дүгээр сард 62.6 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 5774 хүн буюу 10.2 хувиар өсөв.


Хувийн эмнэлгүүд 2011 оны эхний 11 сард 1129.4 мян.хүнд үйлчилж, 25.1 тэрбум төгрөгийн төлбөртэй үйлчилгээ үзүүлжээ. Хувийн эмнэлгээр үйлчлүүлсэн хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 19.7 хувиар өсч, төлбөрт үйлчилгээний хэмжээ 61.4 хувиар нэмэгдлээ.



I.6 Гэмт хэрэг


Зураг-I.15

Улсын хэмжээнд 2011 оны эхний 11 сард 17591 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 342 хэргээр буюу 1.9 хувиар буурчээ (Зураг I.15). Үүнд өмнөх оны мөн үеийнхээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (269), нийгмийн аюулгүй байдлын эсрэг (206), захиргааны журмын эсрэг (44), шүүн таслах ажиллагааны эсрэг (35), хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг (33) зэрэг гэмт хэрэг нэмэгдсэн хэдий ч өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (609), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (237), хүн амын эрүүл мэндийн эсрэг (58) зэрэг гэмт хэрэг буурсан нь голлон нөлөөлөв.




Зураг-I.16

Бүртгэгдсэн гэмт хэргийн 56.4 хувь нь нийслэлд, 42.7 хувь нь аймгуудад, 0.6 хувь нь төмөр замын цагдаагийн хэлтэст, 0.3 хувь нь бусад газарт 2011 оны эхний 11 сард бүртгэгджээ.



Зураг-I.17

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеийнхээс Завхан аймагт 49.7 хувь, Булган аймагт 19.0 хувь, Хэнтий аймагт 17.8 хувь, Хөвсгөл аймагт 15.2 хувь, Өвөрхангай аймагт 10.9 хувь, Төв аймагт 8.6 хувь, Сүхбаатар аймагт 8.4 хувь, Дорноговь аймагт 2.3 хувь, Өмнөговь аймагт 1.4 хувиар нэмэгдэж, харин Говь-Алтай аймагт 21.5 хувь, Дорнод аймагт 21.3 хувь, Сэлэнгэ аймагт 20.7 хувь, Увс аймагт 18.6 хувь, Баянхонгор аймагт 17.0 хувь, Дундговь аймагт 16.8 хувь, Архангай аймагт 15.3 хувь, Говьсүмбэр аймагт 13.2 хувь, Орхон аймагт 6.9 хувь, Ховд аймагт 5.2 хувь, Баян-Өлгий аймагт 4.3 хувь, Дархан-Уул аймагт 2.1 хувь, Улаанбаатар хотод 0.2 хувиар буурсан байна.



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 375 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 125 хэргээр буюу 50.0 хувиар нэмэгдсэн байна. Малын хулгайн 979 гэмт хэрэг бүртгэгдэн нийт гэмт хэргийн 5.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 165 хэргээр буюу 20.3 хувиар өсчээ.

буурсан байна (Зураг I.16).

Бүртгэгдсэн гэмт хэргийн 46.7 хувийг хүндэвтэр, 41.3 хувийг хөнгөн, 9.3 хувийг хүнд, 2.7 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс онц хүнд, хөнгөн хэргийнх тус бүр 0.8 пунктээр нэмэгдэж, хүндэвтэр хэргийнх 0.9 пункт, хүнд хэргийнх 0.7 пунктээр

Улсын дунджаар 2011 оны эхний 11 сард 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд 96 гэмт хэрэг ногдож байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 4 хэрэг буюу 4.0 хувиар буурав.

Түүнчлэн сэжигтэн нь тодорхойгүй байсан 5891 хэргийн 3461 буюу 58.8 хувийнх нь холбогдогч нь тогтоогдож, яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 14.5 пунктээр нэмэгдэв. (Зураг I.17).



Хүүхэд оролцсон хэрэг 2011 оны эхний 11 сард өмнөх оны мөн үеийнхээс 35.6 хувь, бүлэглэн үйлдсэн хэрэг 11.0 хувиар өсч, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 4.8 хувь, эмэгтэй хүн оролцсон хэрэг 0.6 хувиар буурчээ.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч 2011 оны эхний 11 сард 16079 байгаагийн 1029 буюу 6.4 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 2090 буюу 13.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэрэгт холбогдогчдын 5.5 хувь нь өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс байгаа бөгөөд тэдгээрийн эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхээс 0.7 пунктээр өсчээ.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдад ажилчин, малчдын эзлэх хувь 2011 оны эхний 11 сард 16.6 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.2 пункт, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагчдынх 7.8 хувь болж 0.1 пункт, оюутан, сурагчдынх 6.7 хувь болж 0.2 пунктээр нэмэгдэж, харин ажилгүй иргэдийн эзлэх хувь 56.7 болж 0.5 пункт, төрийн албан хаагчдынх 3.8 хувь болж 1.6 пункт, төрийн бус байгууллагын ажиллагчдынх 1.1 хувь болж 0.2 пунктээр буурсан бол хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь өмнөх оны мөн үеийн түвшинд буюу 6.5 хувь байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг үйлдэгдсэн газраар нь авч үзэхэд 2011 оны эхний 11 сард 31.3 хувь нь гэр, орон сууцанд, 18.4 хувь нь гудамж, талбайд, 14.1 хувь нь олон нийтийн газарт, 9.6 хувь нь авто замд, 5.9 хувь нь аж ахуйн нэгжид, 2.1 хувь нь төрийн байгууллагад, 1.6 хувь нь төрийн бус байгууллагад, 1.1 хувь нь нийтийн тээврийн хэрэгсэлд, 15.9 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 2011 оны эхний 11 сард 7294 хүн гэмтэж, 871 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 900 буюу 14.1 хувиар өсч, нас барсан хүний тоо 318 буюу 26.7 хувиар буурсан байна (Зураг 1.19).

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2011 оны эхний 11 сард 34.2 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 10.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 4.5 тэрбум төг буюу 15.0 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 3.0 тэрбум төг буюу 43.3 хувиар өссөн байна (Зураг 1.20). Төрийн өмчит байгууллагын нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 141.5


Зураг-1.18

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын нийгмийн байдал, 2011 оны эхний 11 сарын байдлаар, хувиар




Зураг-1.19

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 11 сарын байдлаар



Зураг-1.20

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, тэрбум төгрөгөөр



сая төгрөгөөр буурсан хэдий ч хувийн өмчит байгууллагынх 3.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нийт нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 3.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд голлон нөлөөлөв. Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 66.6 хувь буюу 22.7 тэрбум төг нь хувийн өмчид ногдож байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо 2011 оны эхний 11 сард 16772 байгаагийн



1092 буюу 6.5 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 6223 буюу 37.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

Харин гэмт хэргийн улмаас нийт 170 байгууллагад хохирол учирсны 115 нь төрийн, 14 нь төрийн бус, 41 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага байна.

Улсын хэмжээнд 2011 оны эхний 11 сард 104.4 мян.хүн эрүүлжүүлэгдэж, 11.4 мян.хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 736 буюу 0.7 хувиар, баривчлагдсан хүний тоо 978 буюу 9.4 хувиар өссөн байна.

II. Макро эдийн засгийн үзүүлэлт

II.1 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 1.3 хувь, 2010 оны 12 дугаар сарынхаас 8.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 10.8 хувиар өслөө.

Хэрэглээний үнийн улсын индекс 2011 оны 11 дүгээр сард 2010 оны 12 дугаар сарынхаас 8.1 хувь өсөхөд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн дүн 11.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 13.8 хувь, тээврийн бүлгийнх 15.9 хувь, боловсролын үйлчилгээнийх 11.9 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Хэрэглээний үнийн улсын индекс 2011 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 10.8 хувь өссөний дотор хувцас, бөс бараа, гутлын бүлгийн дүн 12.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 14.1 хувь, тээврийн бүлгийнх 16.0 хувь, боловсролын үйлчилгээнийх 11.9 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 10.7 хувь, эдгээрээс бусад бүлгийн үнэ 0.3-9.7 хувиар нэмэгджээ.

Хэрэглээний үнийн улсын индекс 2010 оны 11 дүгээр сард оны эхнээс 10.3 хувиар өссөн бол 2011 оны 11 дүгээр сард 8.1 хувь болж, өсөлтийн хурдац 2.2 пунктээр буурчээ (Зураг II.1).


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас бүх аймаг болон нийслэл хотод 0.2-5.0 хувиар өсчээ (Зураг II. 2).

Өрхийн нийт хэрэглээнд өндөр хувийн жин эзэлж буй мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас Говьсүмбэр (5.8%), Сэлэнгэ (3.7%), Төв (1.9%), Дархан-Уул (1.3%), Дорноговь (1.0%), Хэнтий (0.7%), Өмнөговь (0.5%) аймагт буурсан бөгөөд Дундговь, Булган аймагт тогтвортой, бусад 12 аймагт 0.5-7.7 хувиар өслөө.


Хэрэглээний үнийн улсын индекс, бүлгийн дүнгээр

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	Хувь		
		2011 XI	2011 XI	2011 XI
		2010 XI	2010 XII	2011 X
Ерөнхий индекс	100.0	110.8	108.1	101.3
Хүнсний бараа, ундаа, ус	39.7	109.7	104.3	102.1
Согтууруулах ундаа, тамхи	2.8	103.7	102.8	100.1
Хувцас, бөс бараа, гутал	15.3	112.9	111.9	102.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.8	114.1	113.8	100.8
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	5.6	108.5	108.4	100.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.8	102.5	102.4	100.0
Тээвэр	9.0	116.0	115.9	100.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	2.9	100.3	100.3	99.9
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.0	107.2	107.0	100.0
Боловсролын үйлчилгээ	5.4	111.9	111.9	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	1.0	106.8	106.5	100.2
Бусад бараа, үйлчилгээ	2.7	110.7	110.6	100.9

Зураг-II.1



Хүснэгт-II.2





Талх, гурил, будааны дэд бүлгийн үнэ Дорноговь (2.1%), Хэнтий (2.0%), Орхон (1.5%), Сүхбаатар (1.4%), Архангай (0.7%), Дундговь (0.4%), Дархан-Уул (0.1%) аймагт буурч, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Говь-Алтай, Увс, Өвөрхангай, Баянхонгор, Ховд аймагт тогтвортой, бусад 6 аймагт 0.3-4.5 хувиар өсчээ.

Сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ Баян-Өлгий (0.3%) аймагт буурч, бусад 20 аймагт 1.2-43.1 хувиар нэмэгдсэн байна. Сэлэнгэ аймагт хамгийн их буюу 43.1 хувиар өслөө.


Төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ Говьсүмбэр (2.3%), Баян-Өлгий (1.1%) аймагт буурч, Дорноговь, Ховд, Архангай, Өвөрхангай, Төв, Баянхонгор аймагт тогтвортой, бусад 13 аймагт 0.8-36.9 хувиар өссөн байна. Хөвсгөл аймагт хамгийн их буюу 36.9 хувиар өсчээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас Увс аймагт хамгийн их буюу 5.0 хувиар өслөө. Энэ өсөлтөд хүнсний барааны бүлгийн үнэ 10.2 хувь, үүний дотор сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 36.7 хувь, төмс, хүнсний ногооных 24.4 хувь, төрөл бүрийн өөх, тосных 8.4 хувь, ундаа, усных 10.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 6.6 хувиар нэмэгдсэн нь нөлөөллөө.

Хэрэглээний үнийн индекс 2011 оны 11 дүгээр сард өмнөх оны жилийн эцсийнхээс бүх аймагт 2.3-11.4 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2011 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 0.7 хувь, оны эхнээс 9.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 12.3 хувиар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний үнийн ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд



хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дүн 0.7 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 2.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин согтууруулах ундаа, тамхины бүлгийн дүн 0.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 0.1 хувь, тээврийн бүлгийнх 0.2 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийнх 1.3 хувиар өсчээ. Гэр ахуйн тавилга, барааны бүлгийн дүн 0.5 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ болон амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх тус бүр 0.1 хувиар буурч, эдгээрээс бусад бүлгийн үнэ дүнгээрээ тогтвортой байв (Зураг II.3).

Улаанбаатар хотод 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас хэрэглээний сагсны 287 нэрийн бараа, үйлчилгээний 22.0 хувийнх нь үнэ өсч, 5.2 хувийнх нь үнэ буурч, 72.8 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Судалгаанд сонгогдсон хүнсний 72 нэрийн барааны 30.6 хувь буюу 22 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн 2011 оны 11 дүгээр сарын индекс нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт, %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	0.7	Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөд сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 8.5 хувь, жимс, жимсгэнийх 2.2 хувь, төмс, хүнсний ногооных 1.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	0.2	Энэ бүлгийн үнийн өсөлтөд импортын цагаан архины үнэ 6.7 хувь, дотоодын шар айрагны үнэ 2.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.



Хүснэгтийн үргэлжлэл

Хувцас, бөс бараа, гутал	2.7	Энэ бүлгийн үнийн өсөлтөд хөвөн бөс, барааны дэд бүлгийн үнэ 1.1 хувь, бүх төрлийн хувцасных 2.4 хувь, бүх төрлийн гутлынх 3.6 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.
Орон сууц, ус, цахилгаан, түлш	0.1	Орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөд монгол гэрийн үнэ 2.0 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	-0.5	Энэ бүлгийн үнийн бууралтад буйдангийн үнэ 12.5 хувь, гал тогооны ширээ, сандлын үнэ 7.1 хувиар буурсан нь нөлөөлөв.
Тээвэр	0.2	Тээврийн бүлгийн үнийн өсөлтөд АИ-93 автобензиний үнэ 1.9 хувь, олон улсын онгоцны тийзийн үнэ 2.0 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	-0.1	Энэ бүлгийн үнийн бууралтад судалгаанд сонгогдсон гар утасны үнэ 12.5 хувиар хямдарсан нь нөлөөлжээ.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	-0.1	Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнийн бууралтад DVD тоглуулагчийн үнэ 12.4 хувиар буурсан нь нөлөөлөв.
Бусад бараа, үйлчилгээ	1.3	Бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлтөд нүүрний энгэсэгийн үнэ 2.5 хувь, шүдний ооны үнэ 6.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ


Мал аж ахуйн гол нэр төрлийн сарынхаас 3.0-12.0 мян.төг буюу 12.0-43.0 зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн хувиар өсч, харин Архангай, Говьсүмбэр судалгаагаар 2011 оны 11 дүгээр сард аймаг, Улаанбаатар хотод өмнөх сарын үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж түвшинд байв.


Адууны 1 ширхэг ширний дундаж үнэ Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай аймагт хамгийн бага буюу 22.0-25.0 мян.төг, үнэ Баян-Өлгий, Хэнтий, Дундговь, Төв, Архангай, Орхон, Төв аймагт хамгийн их буюу 40.0 мян.төг, адууны ширнийх Ховд аймагт хамгийн бага буюу 22.0 мян.төг, Төв, Хэнтий аймагт хамгийн их буюу 40.0 мян.төг, ямааны цагаан ноолуурын үнэ Дорноговь, Баян-Өлгий, Дундговь аймагт хамгийн бага буюу 40.0-45.0 мян.төг, Архангай аймаг, Улаанбаатар хот, Увс аймагт хамгийн их буюу 52.0-55.0 мян.төг байна.

Адууны 1 ширхэг ширний дундаж үнэ Орхон аймагт өмнөх сарынхаас 0.5 мян.төг буюу 1.0 хувиар өсч, харин Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Дорноговь аймагт 7.0-12.0 мян.төг буюу 15.6-30.0 хувиар буурчээ.

Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Өвөрхангай, Дархан-Уул, Баянхонгор, Төв аймагт өмнөх

Зураг-II.4





Улаанбаатар хотод арилжаалагдсан барилгын гол нэрийн материалын 2011 оны 11 дүгээр сарын дундаж үнэ

Улаанбаатар хотод 2011 оны 11 дүгээр шахмал шалных 2.0 мян.төг буюу 20.0 хувь, сард арилжаалагдсан эх орны үйлдвэрийн шаазан суултуурынх 10.0 мян.төг буюу 12.5 болон ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ-д хувь, крантных 5.0 мян.төг буюу 12.5 хувь, үйлдвэрлэсэн барилгын үндсэн 37 нэр төрлийн өдрийн гэрлийнх (суурьгүй) 0.2 мян.төг буюу материалын дундаж үнийг мэдээнд хамрууллаа. 11.1 хувь, шаазан угаагуурынх 5.0 мян.төг

Өмнөх оны мөн үеийнхээс эх орны буюу 9.1 хувь, ханын цаасных 0.5 мян.төг буюу үйлдвэрийн хуурай палкны үнэ 2011 оны 6.3 хувь, шалны хавтангийнх 50 төг буюу 6.3 11 дүгээр сард 5.0 мян.төг буюу 25.0 хувь, хувь, төмөр хаалганых 3.0 мян.төг буюу 2.2 хөнгөн бетоных 19.5 мян.төг буюу 20.4 хувь, хувиар өсч, харин тараган цавуу болон дүүжин 50 кг-ын савлагаатай цементнийх 0.7 мян.төг таазны үнэ тус бүр 0.5 мян.төг буюу 12.5 буюу 12.1 хувь, захалсан банзных 3.0 мян.төг хувиар буурчээ. БНСУ-д үйлдвэрлэсэн ханын буюу 8.6 хувь, шалны банзных (ховилгүй) 10.0 цаасны үнэ 0.5 мян.төг буюу 11.1 хувиар өсөв. мян.төг буюу 7.1 хувь, ОХУ-д үйлдвэрлэсэн Өмнөх сарынхаас 50 кг-ын савлагаатай хар цаасны үнэ (чулуутай) 5.5 мян.төг буюу цементний эх орны үйлдвэрийн үнэ 4.0 мян. 37.9 хувиар өсчээ. БНХАУ-д үйлдвэрлэсэн төг буюу 38.1 хувь, БНХАУ-д үйлдвэрлэсэн нь хар цаасны (чулуугүй) үнэ 2.0 мян.төг буюу 3.0 мян.төг буюу 27.3 хувиар буурсан байна. 28.6 хувь, цонхны шилнийх (нөлөөгүй) 3.0 Бусад материалын үнэ тогтвортой байлаа. мян.төг буюу 25.0 хувь, 50 кг-ын савлагаатай цементнийх 1.5 мян.төг буюу 23.1 хувь, уян шүршүүрнийх 3.0 мян.төг буюу 20.0 хувь,



II.2 Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2011 оны 11 дүгээр сарын эцэст 6133.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 45.4 тэрбум төг буюу 0.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2194.1 тэрбум төг буюу 55.7 хувиар өсчээ. Мөнгөний нийлүүлэлт оны эхнээс 1328.3 тэрбум төг буюу 27.6 хувиар өсөхөд бараг мөнгө 903.6 тэрбум төг буюу 24.6 хувь, бага мөнгө (M1) 424.6 тэрбум төг буюу 37.5 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна (Зураг II.8).

Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийн хувьд 2011 оны 11 дүгээр сарын эцэст 46.1 хувийг төгрөгийн хадгаламж, 16.4 хувийг гадаад валютын хадгаламж, 17.4 хувийг төгрөгийн харилцах, 12.1 хувийг гадаад валютын харилцах, 8.0 хувийг банкнаас гадуурх мөнгө эзэлж байна (Зураг II.7). Мөнгөний нийлүүлэлтэд гадаад валютын хадгаламжийн эзлэх хувь өмнөх сарынхаас 1.6 пункт, гадаад валютын харилцахынх 0.5 пунктээр өсч, харин төгрөгийн харилцахын эзлэх хувь өмнөх сарынхаас 0.9 пункт, төгрөгийн хадгаламжийнх 0.8 пункт банкнаас гадуурх мөнгөнийх 0.4 пунктээр буурчээ.


Бага мөнгө 2011 оны 11 дүгээр сарын эцэст 1556.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 66.8 тэрбум төг буюу 4.1 хувиар буурав. Бага мөнгө өмнөх оны мөн үеийнхээс 560.4 тэрбум төг буюу 56.3 хувиар нэмэгдэхэд төгрөгийн харилцах 423.1 тэрбум төг буюу 65.6 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Иргэд, байгууллагын нийт хадгаламж 2011 оны 11 дүгээр сарын эцэст 3831.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 76.6 тэрбум төг буюу 2.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1450.8 тэрбум төг буюу 60.9 хувиар өсчээ. Төгрөгийн хадгаламж 2011 оны 11 дүгээр сарын эцэст 2826.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 27.1 тэрбум төг буюу 0.9 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1077.3 тэрбум төг буюу 61.6 хувиар өсөв. Гадаад валютын хадгаламж 2011 оны 11 дүгээр сарын эцэст 1004.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 103.7 тэрбум төг буюу 11.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 373.5 тэрбум төг буюу 59.2 хувиар нэмэгджээ.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2011 оны 11 дүгээр сарын эцэст 678.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 16.0 тэрбум төг буюу 2.3 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 206.0 тэрбум төг буюу 43.6 хувиар өсчээ.

Зураг-II.6

Мөнгөний нийлүүлэлт (M2), хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх сар=100)



Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төг

Үзүүлэлт	2010 XI	2011 X	2011 XI
Мөнгөний нийлүүлэлт M2	3 939.6	6 088.3	6 133.7
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	45.1	57.2	55.7
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	1.7	0.4	0.7
Нийт хадгаламж	2 380.7	3 754.9	3 831.5
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	38.0	63.0	60.9
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	3.3	2.0	2.0
Төгрөгийн хадгаламж	1 749.3	2 853.7	2 826.6
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	52.4	72.3	61.6
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	5.6	2.3	-0.9
Валютын хадгаламж	631.4	901.2	1 004.9
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	9.3	39.1	59.2
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	-2.5	0.9	11.5


Зураг-II.7

Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, хувиар, 2011 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар



Зураг-II.8

Мөнгөний нийлүүлэлт (M2), бага мөнгө (M1) болон бараг мөнгөний өөрчлөлт сарын эцэст, хувиар, (өмнөх оны мөн үе=100)



Эх үүсвэр:* Монголбанкны статистикийн сарын бюллетень



Нөөц мөнгө (M0) 2011 оны 11 дүгээр сарын эцэст 1516.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 32.4 тэрбум төг буюу 2.2 хувиар өслөө. Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкуудын харилцах, хадгаламж өмнөх сарынхаас 48.7 тэрбум төг буюу 6.2 хувиар өсч, 839.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Банкуудын нийт актив 2011 оны 11 дүгээр сарын эцэст 7907.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 199.5 тэрбум төг буюу 2.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2665.7 тэрбум төг буюу 50.9 хувиар өслөө.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2011 оны 11 дүгээр сарын эцэст 5438.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 216.8 тэрбум төг буюу 4.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2326.2 тэрбум төг буюу 74.7 хувиар өсчээ. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл оны эхнээс 1998.5 тэрбум төг буюу 58.1 хувиар өсөхөд хэвийн зээл 2048.3 тэрбум төг буюу 68.8 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.

Зээлийн өрийн үлдэгдлийг эзэмшигчээр нь авч үзэхэд 2011 оны 11 дүгээр сарын эцэст нийт зээлийн 2969.6 тэрбум төг буюу 54.6 хувь нь хувийн секторт, иргэдийнх 2402.0 тэрбум төг буюу 44.2 хувь, улсын байгууллагынх 41.7 тэрбум төг буюу 0.8 хувь, бусад санхүүгийн байгууллагынх 17.7 тэрбум төг буюу 0.3 хувь, бусад байгууллагынх 7.8 тэрбум төг буюу 0.1 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2011 оны 11 дүгээр сарын эцэст 343.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 4.2 тэрбум төг буюу 1.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 27.7 тэрбум төг буюу 7.5 хувиар буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.3 хувийг эзэлж, өмнөх сарынхаас 0.4 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 5.6 пунктээр буурчээ.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2011 оны 11 дүгээр сарын эцэст 71.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 0.5 тэрбум төг буюу 0.7 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 18.7 тэрбум төг буюу 20.7 хувиар буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх сарынхаас 0.1 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 1.6 пунктээр буурсан байна.

Зээлийн өрийн үлдэгдэл, чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл сарын эцэст, тэрбум төг

Үзүүлэлт	2010 XI	2011 X	2011 XI
Зээлийн өрийн үлдэгдэл	3 112.5	5 221.9	5 438.7
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	18.3	69.0	74.7
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	0.7	3.2	4.2
Чанаргүй зээл	370.9	347.5	343.2
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 18.7	- 13.6	- 7.5
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 7.8	- 2.7	- 1.3
Хугацаа хэтэрсэн зээл	90.2	71.0	71.5
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 45.8	- 9.7	- 20.7
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	14.7	17.4	0.7
Зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь	11.9	6.7	6.3
Зээлийн өрийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь	2.9	1.4	1.3


Зураг-II.9

Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төг



Зураг-II.10

Зээлийн жилийн хүү, сарын эцэст, хувиар



Энэ оны 11 дугаар сарын эцэст аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 66.9 хувь нь ХААН банк, Голомт банк, Худалдаа, хөгжлийн банкинд ногдож байна.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2011 оны 10 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 0.2 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 3.6 пунктээр буурч, жилийн хүү 15.9 хувь болжээ. Валютын зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарынхаас 1.2 пунктээр өсч, өмнөх оны мөн үеийнхээс 0.5 пунктээр буурч, жилийн хүү 13.3 хувь боллоо (Зураг II.10).



Гадаад валютын цэвэр албан нөөц 2011 оны 11 дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 146.4 сая ам.доллараар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 601.3 сая ам.доллараар нэмэгдэж 2291.8 сая ам.долл болсон нь манай улсын импортын 18.3 долоо хоног буюу 4.6 сарын хэрэгцээг хангахаар байна (Зураг II.11).

Үнэт цаасны зах зээл

Үнэт цаасны арилжаа 2011 оны 11 дүгээр сард 22 өдөр явагдаж, 34.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 10.1 сая ш үнэт цаас арилжигдсан байна. Гүйлгээний хэмжээ 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 17.1 тэрбум төг буюу 33.5 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 7.7 тэрбум төг буюу 29.3 хувиар өсчээ. Арилжсан үнэт цаасны тоо өмнөх сарынхаас 2.2 сая ш буюу 28.4 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 64.1 мян ш буюу 0.6 хувиар буурлаа.


Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2011 оны 11 дүгээр сард 21148.7 болж, өмнөх сарынхаас 486.7 нэгжээр өсчээ (Зураг II.12). Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2011 оны 11 дүгээр сарын эцэст 2155.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 131.7 тэрбум төг буюу 5.8 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 835.7 тэрбум төг буюу 63.3 хувиар өслөө (Зураг II.13).

“РЕМИКОН” хувьцаат компанийн 8.0 сая ш хувьцаа 2011 оны 11 дүгээр сард арилжигдсан нь хамгийн идэвхтэй арилжаалсан үнэт цаас байв.

Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 11 дүгээр сард 1323.4 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 19.2 төг буюу 1.5 хувиар суларсан байна. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 2.5 хувь, 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 2.4 хувиар суларчээ (Зураг II.14).

Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 11 дүгээр сард 1793.8

Зураг-II.11




Зураг-II.12



Зураг-II.13



Зураг-II.14




Монголбанкны төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг

Үзүүлэлт	2010 XI	2011 X	2011 XI
Ам. Доллар	1 304.2	1 291.9	1 323.4
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 8.9	- 1.1	1.5
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 0.1	2.5	2.4
Евро	1 750.5	1 771.2	1 793.8
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 17.9	- 2.3	2.5
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 3.5	2.0	1.3
Юань	191.4	202.8	208.2
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 8.7	3.6	8.8
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 2.2	2.8	2.7
Рубль	41.2	41.3	42.9
Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100	- 16.8	- 4.2	4.1
Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100	- 4.5	0.5	3.9



төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 43.3 төг буюу 2.5 хувиар суларчээ. Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 2.0 хувиар суларч, 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 1.3 хувиар суларсан байна (Зураг II.15).

Зураг-II.15



Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 11 дүгээр сард 208.2 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 16.8 төг буюу 8.8 хувиар суларчээ (Хүснэгт II.3). Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 2.8 хувь, 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 2.7 хувиар суларчээ (Зураг II.16).

Зураг-II.16



Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 11 дүгээр сард 42.9 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.7 төг буюу 4.1 хувь суларчээ. Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2011 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.5 хувиар, 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 3.9 хувиар суларлаа (Зураг II.17).

Зураг-II.17




II.3 Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2011 оны эхний 11 сард 3860.2 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 3813.3 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсөв 46.9 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Нэгдсэн төсвийн ашиг 2011 оны эхний 10 сарынхаас 142.8 тэрбум төг буюу 75.3 хувиар багассан байна.

Зураг-II.18

Улсын нэгдсэн төсвийн тэнцэл өмнөх оны мөн үеийнхээс 24.1 тэрбум төгрөгөөр буурахад зарлагын өсөлт нь орлогын өсөлтөөс 2.3 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ. (Зураг-II.8)

Улсын нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2011 оны 10 дугаар сард 308.4 тэрбум төг байсан бол 11 дүгээр сард 385.9 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 77.5 тэрбум төг буюу 25.1 хувиар өсчээ. Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2010 оны 10 дугаар сард 355.4 тэрбум төг байсан бол 11 дүгээр сард 528.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 173.3 тэрбум төг буюу 48.8 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн нийт





тэнцэл 2010 оны 10 дугаар сард 47.0 тэрбум төг, 11 дүгээр сард 142.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Төсвийн урсгал орлого 3705.2 тэрбум төг, урсгал зардал 2776.6 тэрбум төг болж 928.6 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Урсгал төсвийн ашиг 2011 оны эхний 10 сарынхаас 19.1 тэрбум төг буюу 2.1 хувиар нэмэгдсэн байна.

Төсвийн орлого

Улсын нэгдсэн төсөвт 2011 оны эхний 11 сард 3860.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 1217.0 тэрбум төг буюу 46.0 хувиар өссөн байна.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 978.4 тэрбум төг буюу 42.2 хувиар нэмэгдэхэд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 318.3 тэрбум төг буюу 85.1 хувиар буурсан хэдий ч дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 521.1 тэрбум төг буюу 68.8 хувь, бусад татварын орлого 309.7 тэрбум төг буюу 2.2 дахин, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 151.8 тэрбум төг буюу 44.8 хувь, гадаад худалдааны татварын орлого 130.7 тэрбум төг буюу 77.4 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 116.6 тэрбум төг буюу 42.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 124.0 тэрбум төг буюу 43.9 хувиар нэмэгдэхэд төсөвт газрын өөрийн орлого 57.2 тэрбум төг буюу 46.5 хувь, хувьцааны ногдол ашиг 26.9 тэрбум төг буюу 2.9 дахин, газрын тосны орлого 17.5 тэрбум төг буюу 39.8 хувь, хүү, торгуулийн орлого 17.3 тэрбум төг буюу 76.2 хувь, навигацын орлого 2.5 тэрбум төг буюу 7.0 хувь, бусад нэр заагдаагүй орлого 2.3 тэрбум төг буюу 5.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 85.5 хувийг татварын орлого, 10.5 хувийг татварын

бус орлого, 3.6 хувийг тогтворжуулалтын сангийн орлого, 0.4 хувийг хөрөнгийн орлого эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс татварын орлогын эзлэх хувь 2.3 пункт, тусламжийн орлого 1.3 пункт, татварын бус орлогынх 0.2 пунктээр буурч, хөрөнгийн орлогынх 0.2 пунктээр өсчээ (Хавсралт 5).

Төсвийн зарлага

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2011 оны эхний 11 сард 3813.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1241.1 тэрбум төг буюу 48.3 хувиар нэмэгдсэн нь зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 6.0 тэрбум төг буюу 14.9 хувиар буурсан хэдий ч татаас, шилжүүлгийн зардал 577.1 тэрбум төг буюу 63.7 хувь, хөрөнгийн зардал 334.4 тэрбум төг буюу 80.7 хувь, бараа, үйлчилгээний зардал 271.2 тэрбум төг буюу 27.5 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 63.9 тэрбум төг буюу 28.6 хувиар өссөнөөс шалтгаалжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 72.8 хувь, хөрөнгийн зардал 19.6 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 7.5 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс урсгал зардлынх 2.4 пункт, эргэж төлөгдөх цэвэр зээлийнх 1.2 пунктээр буурч, хөрөнгийн зардлынх 3.5 пунктээр өсчээ (Хавсралт 5).

Хөрөнгийн зардал

Хөрөнгийн зардалд 2011 оны эхний 11 сард 749.0 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 334.4 тэрбум төг буюу 80.7 хувиар нэмэгджээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс дотоодын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 300.0 тэрбум төг буюу 74.5 хувь, гадаад эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 34.4 тэрбум төг буюу 3.9 дахин өссөнөөс шалтгаалсан байна.

II.4 Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2011 оны 3 дугаар улиралд 2.7 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс алдагдал 169.0 сая ам.доллараар өсчээ.

Урсгал данс

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2011 оны 3 дугаар улиралд 917.2 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 724.2 сая ам.долл буюу 4.8 дахин өслөө. Үүнд

бараа болон үйлчилгээний дансны алдагдал 824.3 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс 642.1 сая ам.долл буюу 4.5 дахин, орлогын дансны алдагдал 172.9 сая ам.долл болж, 100.3 сая ам.долл буюу 2.4 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Үйлчилгээний орлого 2011 оны 3 дугаар улиралд 210.2 сая ам.долл, зарлага 532.0 сая ам.долл, алдагдал 321.8 сая ам.долл



болж, өмнөх оны мөн үеийнхээс 287.2 сая ам.долл буюу 9.3 дахин өссөн байна (Зураг II.19). Үүнд тээврийн үйлчилгээний алдагдал 243.8 сая ам.долл, бусад үйлчилгээнийх 62.6 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс тээврийн үйлчилгээнийх 226.8 сая ам.долл буюу 14.3 дахин, бусад үйлчилгээнийх 29.4 сая ам.долл буюу 1.9 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Сүүлийн жилүүдэд урсгал данс алдагдалтай гарахад эдийн засгийн тэлэлт, уул уурхайн төслийн эрчимжилттэй холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалтаар оруулж буй машин, тоног төхөөрөмжийн импортын өсөлт болон импортын барааны тээвэрлэлтийн зардал нэмэгдэж байгаа нь нөлөөлж байна.


Харин урсгал шилжүүлэг 80.0 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 18.2 сая ам.долл буюу 29.4 хувиар нэмэгджээ. Ажиллагчдын мөнгөн гуйвуулга 2011 оны 3 дугаар улиралд 12.9 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс 29.3 сая ам.долл буюу 69.4 хувиар буурчээ.

Хөрөнгө ба санхүүгийн данс

Хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 2011 оны 3 дугаар улиралд 593.3 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс 277.5 сая ам.долл буюу 87.9 хувиар өссөн байна.

Зураг-II.19

Бараа ба үйлчилгээний орлого, зарлага, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар, сая ам.долл



Шууд хөрөнгө оруулалт нийт дүнгээрээ 2011 оны 3 дугаар улиралд 1285.6 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс 844.6 сая ам.долл буюу 2.9 дахин өсчээ. Үүнд манай улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт 1289.8 сая ам.долл болж, өмнөх оны мөн үеийнхээс 822.2 сая ам.долл буюу 2.8 дахин өссөн нь голлон нөлөөлжээ.


II.5 Гадаад худалдаа

Монгол улс 2011 оны эхний 11 сард дэлхийн 123 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 10271.2 сая ам.долл, үүнээс экспорт 4303.9 сая ам.долл, импорт 5967.3 сая ам.долларт хүрчээ (Зураг II.20). Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 4849.4 сая ам.долл буюу 89.4 хувь, үүнээс импортын хэмжээ 3096.2 сая ам.долл буюу 2.1 дахин, экспортын хэмжээ 1753.2 сая ам.долл буюу 68.7 хувиар өсчээ.

Өмнөх оны эхний 11 сард гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 55.5 хувь нь БНХАУ-д, 19.2 хувь нь ОХУ-д, үлдсэн 25.3 хувь нь бусад улсад ногдож байсан бол 2011

Зураг-II.20

Гадаад худалдааны нийт бараа эргэлт, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, сая ам.долл





оны эхний 11 сард нийт бараа эргэлтийн 56.2 хувь нь БНХАУ-д, 14.8 хувь нь ОХУ-д, 29.0 хувь нь бусад улсад ногдож байна. ОХУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхээс 4.4 пунктээр буурч, БНХАУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь 0.7 пункт, бусад улсынх 3.7 пунктээр өсчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны эхний 11 сард 1663.4 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 1343.0 сая ам.долл буюу 5.2 дахин өсчээ. Үүнд уул уурхайн зориулалттай машин, техник, автомашин, нийтийн тээврийн хэрэгсэл болон газрын тосны бүтээгдэхүүний импортын өсөлт экспортынхоос 39.1 пунктээр илүү байгаа нь нөлөөлөв.

Гадаад худалдааны тэнцэл 2010 оны 11 дүгээр сард 62.5 сая ам.долларын алдагдалтай гарсан бол 2011 оны 11 дүгээр сард 99.7 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 37.2 сая ам.долл буюу 59.5 хувиар өсчээ.

Экспорт


Монгол улс 2011 оны эхний 11 сард нийт 65 оронд бараа, бүтээгдэхүүн экспортолсноос БНХАУ-д 90.9 хувь, ОХУ-д 2.0 хувь, Канад улсад 1.9 хувь, Их Британи улсад 1.4 хувь, Итали улсад 1.1 хувь, БНСУ-д 0.8 хувь, Швейцарь улсад 0.5 хувь, ХБНГУ-д 0.3 хувь, Япон улсад 0.2 хувь ногдож байгаа нь нийт экспортын 99.1 хувийг эзэлж байна (Зураг II.21).

Экспортын 98.3 хувийг эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн эзэлж байна (Зураг II.22).

Экспортын хэмжээ 1753.2 сая ам.доллараар нэмэгдэхэд үнэт ба хагас үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийн экспорт өмнөх оны мөн үеийнхээс 17.8 сая ам.долл, мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүнийх 16.9 сая ам.доллараар буурсан хэдий ч эрдэс бүтээгдэхүүний экспорт 1740.0 сая ам.долл,

Зураг-II.21

Экспортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2011 оны эхний 11 сарын байдлаар



Зураг-II.22

Экспортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, хувиар



Экспортын зарим эрдэс бүтээгдэхүүн, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, мян.т

	2009 I-XI	2010 I-XI	2011 I-XI
Нүүрс	6 119.2	14 622.3	18 467.4
Зэсийн баяжмал	534.1	518.0	524.9
Төмрийн хүдэр	1 337.5	3 123.5	5 085.6
Боловсруулаагүй газрын тос	1 684.0	1 903.3	2 265.7
Цайрын баяжмал	133.2	100.0	110.5
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	11.0	4.7	3.2

нэхмэл бүтээгдэхүүнийх 25.4 сая ам.долл, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэлийнх 14.5 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ. Экспортод нүүрс 45.3 хувь, зэсийн баяжмал 20.9 хувь, төмрийн хүдэр 8.7 хувь, боловсруулаагүй газрын тос 5.3 хувь, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 3.4 хувь, цайрын хүдэр, баяжмал 3.1 хувь, жоншны хүдэр, баяжмал 2.0 хувь, самнасан ноолуур 1.3 хувь, бусад бүтээгдэхүүн 10.0 хувийг эзэлж байна. Нийт экспортод эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхээс зэсийн баяжмалынх 6.1, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтных 3.1, цайрын хүдэр, баяжмалынх 1.2, самнасан ноолуурынх 1.1, жоншны хүдэр, баяжмалынх 0.3, боловсруулаагүй



газрын тосных 0.2 пунктээр буурч, харин нүүрснийх 15.5, төмрийн хүдрийнх 0.2 пунктээр нэмэгджээ.

Импорт

Монгол улс 2011 оны эхний 11 сард нийт 120 оронтой импортын худалдаа хийсний 31.2 хувийг БНХАУ-тай, 24.0 хувийг ОХУ-тай, 8.6 хувийг АНУ-тай, 7.2 хувийг Япон улстай, 5.4 хувийг БНСУ-тай, 4.3 хувийг ХБНГУ-тай, 2.5 хувийг Украин улстай, 1.9 хувийг Канад улстай хийсэн нь нийт импортын 85.1 хувийг эзэлж байна (Зураг II.23).

Нийт импортод ОХУ-ын эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхээс 9.8, БНСУ-ынх 0.3 пунктээр буурч, харин АНУ-ынх 3.4, ХБНГУ болон БНХАУ-ынх тус бүр 1.6, Япон улсынх 1.3, Украин болон Канад улсынх тус бүр 1.2 пунктээр өсчээ.


Өмнөх оны мөн үеийнхээс импортын хэмжээ 3096.2 сая ам.доллараар нэмэгдэхэд машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 1029.0 сая ам.долл, авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн бүлгийн импорт 862.0 сая ам.долл, эрдэс бүтээгдэхүүний импорт 432.3 сая ам.долл, үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүнийх 366.3 сая ам.долл, хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэлийнх 112.4 сая ам.долл, хүнсний бэлэн бүтээгдэхүүнийх 88.5 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлөв. Харин ургамлын гаралтай бүтээгдэхүүнийх 19.7 сая ам.доллараар буурлаа.

Нийт импортын 27.4 хувийг машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг, 23.1 хувийг авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, 18.8 хувийг эрдэс бүтээгдэхүүн, 9.2 хувийг үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүн, 5.0 хувийг хүнсний бэлэн бүтээгдэхүүн, 3.9 хувийг хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 3.6 хувийг хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл, үлдсэн 9.0 хувийг бусад бүлгийн бүтээгдэхүүн эзэлж байна (Зураг II.24).

Импортолсон гурилын биет хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 2.9 мян.т, цахилгаан эрчим хүчний биет хэмжээ 37.4 сая квт.цагаар


Зураг-II.23

Импортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2011 оны эхний 11 сарын байдлаар




Зураг-II.24

Импортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, хувиар



Зураг-II.25

Зарим барааны импорт, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, мян.ам.долл



буурч, харин автобензиний биет хэмжээ 28.0 мян.т, үнийн дүн 98.4 сая ам.долл, суудлын автомашины биет хэмжээ 26.5 мян.ш, үнийн дүн 245.3 сая ам.долл, гурилын үнийн дүн 6.8 сая ам.долл, цахилгаан эрчим хүчнийх 1.6 сая ам.доллараар өсчээ (Зураг II.25).



Газрын тосны бүтээгдэхүүний импорт 2011 оны эхний 11 сард 907.0 мян.т буюу 1005.8 сая ам.долл болж, нийт импортын үнийн дүнгийн 16.9 хувийг эзэлж байна. Газрын тосны бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеийнхээс 148.7 мян.т буюу 19.6 хувиар нэмэгдэв.

Газрын тосны бүтээгдэхүүнийг 2011 оны эхний 11 сард ОХУ, БНХАУ, БНСУ-аас; гурилыг ОХУ болон Казахстан улсаас; цагаан будааг БНХАУ, Вьетнам, ОХУ-аас; элсэн чихрийг Тайланд, Бразил, Колумба, Австрали улсаас; нийтийн тээврийн хэрэгслийг БНСУ, ОХУ-аас; суудлын автомашиныг Япон, БНСУ,

ХБНГУ, Их Британи улс, АНУ-аас; ачааны автомашиныг БНХАУ, АНУ, БНСУ, Беларусь, Энэтхэг улсаас голлон нийлүүлсэн байна.

Импортолсон барааны 79.0 хувийг валютын төлбөртэй худалдаа, 18.7 хувийг гадаадын хөрөнгө оруулалтын бараа, 2.2 хувийг тусламжийн бараа, 0.1 хувийг бусад төрлийн худалдаа эзэлж байна. Өмнөх оны мөн үеийнхээс валютын төлбөртэй худалдааных 12.7, гадаадын тусламжийн барааных 1.1, гадаад зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн худалдааных 0.5, бараа солилцооных 0.1 пунктээр буурч, харин хөрөнгө оруулалтын барааных 14.5 пунктээр өсчээ.

III. Үйлдвэрлэл, үйлчилгээ

III.1 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2011 оны эхний 11 сард 1860.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 175.4 тэрбум төг буюу 10.4 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд газрын тос, нүүрс, төмрийн хүдэр зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 12.1 хувиас 2.3 дахин, нарийн боов, адууны мах, сүлжмэл эдлэл, самнасан ноолуур, талх, амтат ус, ундаа, шингэн сүү, архи, жүүс, шар айраг, цэвэр ус, бетон зуурмаг зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.3-79.9 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Харин зэсийн баяжмал, металл агуулгаараа, алт, цайрын баяжмал, буталмал чулуу, молибдений баяжмал, хайлуур жоншны баяжмал зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.3-10.8 хувь, зүсмэл материал, хонины мах, зайрмаг, гурил, малын тэжээл, цул бетон, тарилгын эм зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.2-96.1 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2011 оны эхний 11 сард 4556.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 910.0 тэрбум төг буюу 25.0 хувиар нэмэгдэв.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл (оны үнээр) 2011 оны 11 дүгээр

Зураг-III.7



Зураг-III.8





Зураг-III.9


сард 415.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 81.5 тэрбум төг буюу 16.4 хувиар буурсан бөгөөд үүний дотор цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 4.6 тэрбум төг буюу 13.0 хувиар өсч, харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийнх 75.3 тэрбум төг буюу 21.4 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 10.8 тэрбум төг буюу 9.9 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2011 оны эхний 11 сард оны үнээр 5085.8 тэрбум төг болж, үүний 3213.7 тэрбум төг буюу 63.2 хувийг гадаад зах зээлд борлуулжээ (Хавсралт 9).

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүний 65.8 хувь нь уул уурхай, олборлох аж үйлдвэрт, 27.0 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 7.2 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт ногдож байна (Зураг III.9). Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 2011 оны эхний 11 сард 3348.8 тэрбум төг болж, 2778.3 тэрбум төг буюу 83.0 хувийг, боловсруулах аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 1373.2 тэрбум төг болж, 435.4 тэрбум төг буюу 31.7 хувийг нь гадаад зах зээлд борлуулав.

Нийт борлуулалтад боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2011 оны эхний 11 сард 27.0 хувь болж, өмнөх оны мөн үеийнхээс 5.5 пунктээр нэмэгдэж, харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 65.8 хувь болж, 4.7 пункт, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 7.2 хувь болж, 0.8 пунктээр буурлаа (Зураг III.9).

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, хувиар



Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо 2011 оны 11 дүгээр сарын эцэст 57253 болж, өмнөх оны мөн үеийнхээс 3456 хүнээр буюу 6.4 хувиар өсчээ. Ажиллагчдын тоо уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 1175 хүн буюу 7.0 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 2283 хүн буюу 10.0 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 2011 оны эхний 11 сард 34311.0 мян.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1327.1 мян.төг буюу 4.0 хувиар өсчээ. Хөдөлмөрийн бүтээмж уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 2177.4 мян.төг буюу 3.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 491.0 мян.төг буюу 2.1 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 653.7 мян.төг буюу 4.7 хувиар өслөө.

III.2 Тээвэр

Төмөр замын тээврээр 2011 оны эхний 11 сард 16783.2 мян.т ачаа, давхардсан тоогоор 3540.0 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1500.6 мян.т буюу 9.8 хувь, зорчигчдын тоо 300.5 мян.хүн буюу 9.3 хувиар өсчээ (Зураг III.10.а, III.10.б).

Өмнөх оны мөн үеийнхээс төмөр замаар тээсэн нийт ачааны хэмжээ 1500.6 мянган тонноор өсөхөд дамжин өнгөрсөн ачааны

хэмжээ 392.9 мян.т буюу 18.2 хувиар буурсан хэдий ч дотоодод тээвэрлэсэн ачаа 367.5 мян.т буюу 4.9 хувь, экспортын ачаа 1137.5 мян.т буюу 27.3 хувь, импортын ачаа 388.5 мян.т буюу 27.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.

Төмөр замын тээврийн орлого 2011 оны 11 дүгээр сард 30.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 5.2 тэрбум төг буюу 14.7 хувь, тээсэн ачаа 1582.1 мян.т болж, 280.1 мян.т




буюу 15.0 хувиар буурч, зорчигчдын тоо 339.0 мян.хүн болж, 5.6 мян.хүн буюу 1.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс орлого 9.6 тэрбум төг буюу 46.7 хувь, зорчигчдын тоо 22.4 мян.хүн буюу 7.1 хувь, тээсэн ачаа 18.5 мян.т буюу 1.2 хувиар нэмэгджээ.

Төмөр замын нийт ачаа тээвэрлэлтэд экспортын ачаа 31.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 4.3 пунктээр нэмэгдэхэд төмрийн хүдрийн тээвэрлэлт 1109.1 мян.т буюу 37.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин төмөр замаар дотоодод тээвэрлэсэн

Зураг-III.10а

Төмөр замын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, мян.хүн




Төмөр замын тээврийн орлого, зорчигчдын тоо болон тээсэн ачаа, сараар

Хугацаа, сараар	Тээврийн орлого, сая төг	Зорчигчдын тоо, мян.хүн	Тээсэн ачаа, мян.т
2009 I	13 278.5	250.9	1 034.7
II	17 159.6	262.2	966.4
III	12 379.4	247.4	1 114.6
IV	17 200.0	235.8	1 113.8
V	24 184.2	274.2	1 224.3
VI	20 030.5	290.4	1 076.1
VII	20 015.9	289.1	1 161.5
VIII	14 229.0	344.7	1 205.2
IX	27 635.1	248.0	1 286.8
X	20 169.4	256.5	1 312.8
XI	18 378.8	164.4	1 323.7
2009 I-XI	204 660.4	2 863.4	12 819.8
2010 I	19 860.5	257.9	1 277.8
II	18 766.2	294.5	1 169.5
III	21 037.8	248.3	1 198.9
IV	21 538.6	259.7	1 222.3
V	24 687.0	301.1	1 268.5
VI	26 479.8	316.3	1 366.0
VII	27 888.0	316.6	1 434.2
VIII	30 577.3	364.4	1 556.3
IX	29 608.3	269.5	1 646.9
X	30 339.3	294.4	1 578.7
XI	20 663.7	316.7	1 563.5
2010 I-XI	271 446.6	3 239.5	15 282.6
2011 I	23 010.5	286.9	1 397.5
II	22 301.9	278.0	1 156.9
III	24 280.0	284.3	1 430.6
IV	35 853.4	294.3	1 596.7
V	35 786.1	330.2	1 439.9
VI	29 870.0	342.4	1 528.3
VII	43 092.2	361.6	1 627.3
VIII	38 995.6	384.0	1 586.5
IX	35 052.4	305.8	1 575.2
X	35 530.5	333.4	1 862.2
XI	30 312.1	339.0	1 582.1
2011 I-XI	354 084.7	3 540.0	16 783.2
<u>2011 I-XI</u> / <u>2010 I-XI</u> %	130.4	109.3	109.8
<u>2011 XI</u> / <u>2010 XI</u> %	146.7	107.1	101.2
<u>2011 XI</u> / <u>2011 X</u> %	85.3	101.7	85.0

Зураг-III.10б

Төмөр замын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, мян.т



ачаа нийт ачаа тээвэрлэлтийн 47.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 2.2 пунктээр буурсан байна.

Төмөр замын тээврийн салбарын орлого 2011 оны эхний 11 сард 354.1 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 82.6 тэрбум төг буюу 30.4 хувиар өсчээ.

Агаарын тээврээр 2011 оны эхний 11 сард 2.6 мян.т ачаа, давхардсан тоогоор 525.5 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1.1 мян.т буюу 71.5



хувь, зорчигчдын тоо 160.8 мян.хүн буюу 44.1 хувиар өсчээ (Зураг III.19.а, III.19.б).


Агаарын тээврээр тээсэн ачаа 2011 оны 11 дүгээр сард 337.1 т болж өмнөх сарынхаас 4.8 т буюу 1.4 хувиар буурч, зорчигчдын тоо 48.6 мян.хүн болж, өмнөх сарынхаас 1.8 мян.хүн буюу 3.8 хувь, орлого 15.1 тэрбум төг болж, 2.5 тэрбум төг буюу 19.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс орлого 7.5 тэрбум төг буюу 99.3 хувь, зорчигчдын тоо 15.4 мян.хүн буюу 46.1 хувь, тээсэн ачаа 207.9 т буюу 2.6 дахин өссөн байна.

Агаарын тээврээр дотоодод зорчсон зорчигчдын тоо өмнөх оны мөн үеийнхээс 65.7 мян.хүн буюу 59.0 хувь, олон улсад зорчсон зорчигчдын тоо 95.1 мян.хүн буюу 37.5 хувиар өсөв.

Агаарын тээврийн салбарын орлого 2011 оны эхний 11 сард 149.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 44.2 тэрбум төг буюу 41.8 хувиар нэмэгджээ.


Зураг-III.11.а

Агаарын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, мян.хүн



Зураг-III.11.б

Агаарын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, т



Агаарын тээврийн орлого, зорчигчдын тоо болон тээсэн ачаа, сараар			
Хугацаа, сараар	Тээврийн орлого, сая төг	Зорчигчдын тоо, мян.хүн	Тээсэн ачаа, т
2009 I	6 020.5	18.5	109.8
II	5 371.8	15.6	73.5
III	3 981.7	14.1	51.2
IV	8 145.2	20.3	92.0
V	6 858.9	19.4	93.0
VI	10 085.0	28.3	120.2
VII	15 591.1	44.7	140.7
VIII	18 676.6	48.3	131.8
IX	13 361.2	31.1	140.1
X	8 545.4	23.0	140.6
XI	7 035.0	23.6	141.7
2009 I-XI	103 672.3	286.9	1 234.6
2010 I	6 759.1	24.1	138.5
II	6 096.3	19.8	102.1
III	7 206.7	24.2	104.1
IV	6 648.5	22.1	96.4
V	10 295.7	26.5	108.6
VI	8 207.6	37.6	123.4
VII	16 239.8	51.4	161.1
VIII	18 690.2	55.1	272.3
IX	9 650.3	37.9	141.9
X	8 353.0	32.7	126.9
XI	7 567.1	33.3	129.2
2010 I-XI	105 714.4	364.7	1 504.5
2011 I	9 266.4	36.5	127.3
II	7 834.9	30.2	124.1
III	8 211.9	34.0	150.8
IV	11 553.2	37.3	152.8
V	12 300.6	41.8	145.7
VI	11 498.9	54.8	258.5
VII	24 731.9	71.1	319.3
VIII	24 509.8	73.3	347.5
IX	12 348.5	51.1	275.7
X	12 574.6	46.9	341.9
XI	15 082.7	48.6	337.1
2011 I-XI	149 913.5	525.5	2 580.7
2011 I-XI / 2010 I-XI %	141.8	144.1	171.5
2011 XI / 2010 XI %	199.3	146.1	260.9
2011 XI / 2011 X %	119.9	103.8	98.6



IV. Бусад

Зураг-IV.1


IV.1 Цаг уур, агаарын бохирдол

Ус, цагуурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2011 оны 11 дүгээр сард Дорнод аймгийн Чойбалсан суманд (24.9 мм) орсон байна. Энэ оны 11 дүгээр сард Өмнөговь аймгийн Ханбогд суманд хамгийн дулаан буюу 13.1 хэм, Завхан аймгийн Тосонцэнгэл суманд хамгийн хүйтэн буюу -36.4 хэм байлаа. Салхины хурд Говь-Алтай аймгийн Цогт суманд 18 м/с хүрчээ.

Аймгийн төв, нийслэлд агаарын дундаж хэм 2011 оны 11 дүгээр сард олон жилийн дунджаас 0.4 хэм, өмнөх оны мөн үеийнхээс 3.5 хэм хүйтэн байлаа.


Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2011 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 30 удаа, Баруун дөрвөн замын орчимд 28 удаа, Хархорин захын орчимд 23 удаа, Мишээл экспо төв, 32-ын тойрог орчимд тус бүр 22 удаа, 1-р хороолол орчимд 16 удаа, Офицеруудын ордон орчимд 5 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 13-р хороолол, 32-ын тойрог орчимд тус бүр 28 удаа, Баруун дөрвөн замын орчимд 26 удаа, Мишээл экспо төвийн орчимд 22 удаа, Офицеруудын ордон орчимд 18 удаа, 1-р хороолол орчимд 17 удаа, Хархорин захын орчимд 14 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 32-ын тойрог орчимд 26 удаа, 13-р хороолол орчимд 21 удаа, Баруун дөрвөн зам, Мишээл экспо төвийн орчимд тус бүр 15 удаа, Хархорин захын орчимд 9 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн замын орчимд 26 удаа, 13-р хороолол орчимд 24 удаа, агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ (Зураг IV-1, 2).

Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн хоногийн дундаж агууламжийн хамгийн их хэмжээ, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар (мг/м³)



Зураг-IV.2

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламжийн хамгийн их хэмжээ, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар (мг/м³)



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2011 оны эхний 11 сард 3268 удаа гарсны улмаас 202 хүн амь насаа алдаж, 165.5 мян.

Аюулт үзэгдэл, осол, жил бүрийн эхний 11 сарын байдлаар*

Үзүүлэлт	2009 I-XI	2010 I-XI	2011 I-XI	2011 I-XI / 2010 I-XI %
Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо	2 190	2 765	3 268	118.2
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо	235	198	202	102.0
Шатсан гэр, орон сууцны тоо	696	1 444	1 454	100.7
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтан, мян.тол	329.0	9 734.1	165.5	1.7
Объектын түймрийн тоо	1 865	2 349	2 802	119.3
Учирсан хохирлын хэмжээ, тэрбум төг	8.5	534.6	5.0	0.9

Тайлбар: *-Онцгой байдлын ерөнхий газрын мэдээ



толгой мал, тэжээвэр амьтан хорогджээ. Өмнөх оны мөн үеийнхээс аюулт Энэ оны эхний 11 сард объектын түймэр үзэгдэл, ослын тохиолдол 503, амь насаа 2802 удаа, бичил уурхай, нурангины осол алдсан хүний тоо 4-өөр нэмэгдэв. 20 удаа, мал, амьтны галзуу өвчин 39 Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, удаа, гол, нуурын усанд унасан осол 92 устгасан мал, тэжээвэр амьтдын тоо өмнөх удаа бүртгэгджээ. Энэ оны эхний 11 сард оны мөн үеийнхээс 9.6 сая толгойгоор аюулт үзэгдэл, ослын улмаас 5.0 тэрбум багасчээ төгрөгийн хохирол учирсан байна. Усны ослоор 88 хүн, объектын түймрээр 75 хүн, бичил уурхай, нурангины ослоор 19 хүн амь насаа алджээ.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

С.МЭНДСАЙХАН

2011 оны 12-р сарын 9

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 11 сарын байдлаар, бүс, аймаг, нийслэлээр

Хавсралт 1

Аймаг, нийслэл	ХХҮХ-т бүртгэлтэй ажилгүйдлийн тоо				Орон нутгийн төсвийн нийт орлого, зарлагын харьцаа, хувиар				Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо*				Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо					
	2009 I-XI		2010 I-XI		2009 I-XI		2010 I-XI		2009 I-XI		2010 I-XI		2009 I-XI		2010 I-XI		2011 I-XI	
	2009 I-XI	2010 I-XI	2011 I-XI	2012 I-XI	2009 I-XI	2010 I-XI	2011 I-XI	2012 I-XI	2009 I-XI	2010 I-XI	2011 I-XI	2012 I-XI	2009 I-XI	2010 I-XI	2011 I-XI	2012 I-XI	2013 I-XI	2014 I-XI
ДҮН	39 755	40 618	62 726	106.9	105.4	125.3	18 583	17 933	17 591	34 861	36 741	38 339	7 715	7 829	13 691	10 081	10 818	10 818
Баруун бүс	7 715	7 829	13 691	105.1	102.5	106.4	1 395	1 332	1 273	3 177	3 162	3 688	1 358	1 168	2 312	2 567	2 567	2 567
БӨ	1 358	1 168	1 026	111.1	98.1	104.4	276	324	310	811	637	434	1 022	862	1 421	534	534	534
ГО	1 913	2 794	2 249	98.8	91.0	103.4	300	159	238	553	641	810	1 913	1 913	1 739	2 136	2 136	2 136
ЗА	2 405	1 695	1 073	105.6	117.0	102.7	364	388	316	642	680	1 110	2 405	1 695	2 694	1 253	2 694	2 694
УВ	1 017	1 310	2 211	104.0	94.6	106.1	343	289	274	755	473	731	1 017	1 310	2 385	2 283	2 283	2 283
ХО	14 518	13 691	10 081	111.7	102.1	120.1	2 136	2 270	2 249	7 070	6 388	7 140	1 882	2 312	2 567	2 567	2 567	2 567
АР	1 882	2 312	2 567	103.6	100.8	114.0	381	413	350	454	450	887	2 983	3 140	1 308	1 308	1 308	1 308
БХ	2 528	1 421	534	107.6	107.8	107.8	264	200	238	990	711	961	2 528	1 421	1 421	1 421	1 421	1 421
БУ	1 887	1 739	2 136	116.0	101.4	126.2	330	481	448	845	698	901	1 887	1 739	1 739	1 739	1 739	1 739
ОР	2 902	2 694	1 253	104.5	97.5	108.3	329	393	436	930	862	1 204	2 902	2 694	2 694	2 694	2 694	2 694
ӨВ	2 336	2 385	2 283	105.7	102.3	109.8	471	395	455	1 960	1 844	1 508	2 336	2 385	2 385	2 385	2 385	2 385
ХӨ	5 825	6 994	6 996	106.1	105.3	118.4	3 200	2 935	2 785	4 351	4 410	5 761	181	132	465	465	465	465
Төвийн бүс	181	132	465	114.1	110.6	96.7	150	114	99	141	219	272	1 715	1 807	2 389	2 389	2 389	2 389
ГС	1 715	1 807	2 389	101.9	114.0	97.1	573	559	547	1 138	949	1 143	515	646	657	657	657	657
ДА	515	646	657	127.4	106.9	108.3	533	476	487	1 014	1 152	1 105	570	869	656	656	656	656
ДО	570	869	656	105.3	107.3	104.4	236	220	183	202	288	541	454	926	620	620	620	620
ДУ	1 318	1 103	1 107	104.3	103.7	127.6	283	285	289	267	263	841	1 318	1 103	1 107	1 107	1 107	1 107
ӨМ	1 072	1 511	1 102	99.0	98.0	95.2	690	560	608	427	585	865	1 072	1 511	1 511	1 511	1 511	1 511
СЭ	3 067	3 393	4 235	110.1	108.1	104.8	1 371	1 189	1 195	3 623	3 352	3 736	827	943	1 819	1 819	1 819	1 819
ТӨ	827	943	1 819	106.1	117.0	113.7	593	489	385	1 924	1 752	2 013	1 332	1 209	859	859	859	859
Зүүн бүс	908	1 241	1 557	106.1	98.8	117.9	587	545	642	877	1 067	1 144	908	1 241	1 557	1 557	1 557	1 557
ДД	8 630	8 711	34 040	105.2	107.2	139.9	10 282	9 942	9 920.0	16 640	19 429	18 014	8 630	8 711	34 040	34 040	34 040	34 040
СҮ	8 630	8 711	34 040	105.2	107.2	139.9	10 282	9 942	9 920.0	16 640	19 429	18 014	8 630	8 711	34 040	34 040	34 040	34 040
ХЭ	8 630	8 711	34 040	105.2	107.2	139.9	10 282	9 942	9 920.0	16 640	19 429	18 014	8 630	8 711	34 040	34 040	34 040	34 040
Улаанбаатар	8 630	8 711	34 040	105.2	107.2	139.9	10 282	9 942	9 920.0	16 640	19 429	18 014	8 630	8 711	34 040	34 040	34 040	34 040

* - Төмөр замын цагдаагийн хэлтэс, Иргэний агаарын тээврийн цагдаагийн тасагт бүртгэгдсэн болон Монгол Улсын иргэдийн хилийн чанадад үйлдсэн хэргүүдийг хамааруулав.



ХАМГИЙН ӨНДӨР, ХАМГИЙН БАГА ҮЗҮҮЛЭЛТТЭЙ АЙМАГ, ХОТ

	Хэмжих нэгж	2011 оны эхний 11 сар				
		Улсын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал (нэг кв км-т ногдох хүний тоо)	тоо	1.8	УБ	250.0	ӨМ	0.3
			ОР	109.4	ГО	0.4
			ДА	28.3	ДО, ДД, ДУ	0.6
1000 хүнд ногдох төрөлт	0/00*	22.9	ОР	26.6	ТӨ	9.5
			УБ	26.4	БУ	14.0
			ДА	24.9	ДУ	15.3
1000 хүнд ногдох нас баралт	0/00*	5.6	ХӨ	6.4	ХО	4.0
			СҮ	6.2	СЭ	4.1
			УБ	6.1	БӨ	4.2
Нялхсын нас баралт (амьд төрсөн 1000 хүүхдэд)	0/00*	16	ХӨ	30	СЭ	5
			ӨВ, ТӨ	26	ГС	6
			УВ	25	ДА	9
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгчид	0/000**	135	ДД	268	БӨ	42
			ГС, БХ	194	ХО	81
			ДО	183	СЭ	92
Төрсөн 100 000 эхэд ногдох эхийн эндэгдэл	0/0000	45	ӨВ	130	БХ, БУ, ДО, ДД, ДУ, ДА	
			СЭ	115	ӨМ, ТӨ, УВ, ХЭ, ГС	0
			ХО	91	УБ	42
			БӨ	85	ОР	43
			СҮ	84	АР	53
			ГО	81	ХӨ	69
			ЗА	78		
Орон нутгийн төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	%	125.3	ӨМ	127.6	СҮ	87.3
			ОР	126.2	ТӨ	95.2
			ХЭ	117.9	ГС	96.7

*-промилль

**- продицмилль



Хавсралт № 3

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ

жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар

	ХҮИ, %		Хүнсний гол нэрийн барааны нэгжийн үнэ, төг															
	2011.XI	2011.XI	I зэргийн гурил, кг			Хонины мах, кг			Үхрийн мах, кг			Цагаан будаа, кг			Шингэн сүү, л			
	2010.XII	2011.X	2009.XI	2010.XI	2011.XI	2009.XI	2010.XI	2011.XI	2009.XI	2010.XI	2011.XI	2009.XI	2010.XI	2011.XI	2009.XI	2010.XI	2011.XI	
Баруун бүс																		
БӨ	108.5	101.0	520	900	530	1600	2200	3800	2000	2500	4500	1200	1500	1600	1800	1500	1500	
ГО	109.4	101.7	800	1100	950	1800	2800	3200	1800	3000	4000	1400	1700	1700	1500	2000	1600	
ЗА	105.5	103.0	800	1000	900	2000	3200	3800	2000	3200	4000	1500	1500	1600	1500	1500	1400	
УВ	107.3	105.0	800	1000	800	2000	2700	3500	2000	2700	3500	1300	1500	1600	1500	1200	1200	
ХО	106.3	101.3	800	1300	850	1800	2500	4300	2200	3000	4500	1300	1500	1600	1500	1500	1300	
Хангайн бүс																		
АР	110.4	101.3	650	840	690	1800	2500	3800	2400	3300	4400	1300	1700	1700	1500	1200	1200	
БХ	104.8	101.2	720	1000	780	1800	2500	3200	2300	3200	4000	1200	1600	1600	1500	1400	1400	
БУ	109.3	101.5	600	740	680	2200	2500	4000	2400	3500	4500	1300	1800	1800	800	1000	1000	
ОР	105.8	101.2	580	820	600	2200	2700	3700	2700	3500	4000	1250	1550	1550	850	1000	1000	
ӨВ	107.3	102.7	800	900	800	1400	2300	3500	2000	2800	4500	1200	1600	1700	1500	2200	1400	
ХӨ	107.7	103.0	800	1100	800	1900	2800	3600	2000	2800	4200	1300	1800	1800	800	1200	1200	
Төвийн бүс																		
ГС	108.2	101.1	680	850	743	1900	2700	3800	2400	3500	4200	1200	1650	1600	1000	900	1200	
ДА	104.9	100.3	700	875	820	2100	2900	3650	2400	3600	4100	1300	1750	1700	800	1000	1000	
ДО	111.4	100.2	720	900	700	2000	2500	3550	3000	3800	5000	1200	1570	1550	1700	1800	1900	
ДУ	110.4	100.6	797	957	750	1450	2600	3400	-	-	2600	1258	1470	1500	2000	1800	1800	
ӨМ	110.8	100.8	850	900	850	2300	3300	4500	-	-	5000	1250	1600	1700	2000	2000	2000	
СЭ	102.3	101.4	800	850	700	2200	2800	4200	2300	3200	4400	1300	1600	1500	750	1000	800	
ТӨ	104.6	100.6	600	820	640	2200	3000	3800	2500	3800	4500	1300	1550	1600	1000	1200	1000	
Зүүн бүс																		
ДД	110.3	103.0	640	1100	680	2200	2300	3900	2600	2800	4500	1100	1400	1400	800	1000	1000	
СҮ	103.1	102.8	650	1000	780	2000	3000	3500	2500	3800	3800	1200	1500	1400	1200	1500	1000	
ХЭ	109.0	101.3	900	1050	850	2500	2500	3600	2700	3300	4500	1300	1800	1600	1000	1000	1000	
Улаанбаатар																		
УБ	109.6	100.7	668	720	700	2350	3200	4100	2900	3540	4695	1400	1758	1655	1083	1170	1100	



Хавсралт № 3-ийн үргэлжлэл

	Хүнсний гол нэрийн барааны нэгжийн үнэ, төг											
	Элсэн чихэр, кг				Ногоон цай, 2 кг				Төмс, кг			
	2009.XI	2010.XI	2011.XI	2009.XI	2010.XI	2011.XI	2009.XI	2010.XI	2011.XI	2009.XI	2010.XI	2011.XI
Баруун бүс												
БӨ	1 500	1 800	1 900	3 500	3 650	3 600	350	400	500	800	1 000	1 000
ГО	1 400	1 700	1 700	5 000	5 500	6 000	500	500	800	1 000	1 000	1 500
ЗА	1 500	1 800	1 700	3 500	3 450	3 800	500	600	500	1 000 #	1 400	1 000
УВ	1 400	1 600	1 800	4 500	4 300	5 500	400	400	600	1 200	1 000	1 500
ХО	1 600	1 800	1 800	4 500	4 800	4 800	300	400	400	1 000 #	1 300	1 000
Хангайн бүс												
АР	1 400	1 800	1 700	3 200	3 300	3 500	650	700	800	800	850	1 000
БХ	1 400	1 800	1 800	4 000	4 300	4 400	700	700	800	800	1 000	1 200
БУ	1 500	1 800	1 800	3 000	3 500	3 500	400	500	700	700	750	1 000
ОР	1 350	1 650	1 500	3 500	4 500	5 000	350	500	500	800	1 000	1 000
ӨВ	1 500	1 800	1 800	4 500	4 500	4 500	600	800	800	800	800	800
ХӨ	1 550	1 700	1 700	5 000	5 100	4 500	400	600	800	1 000	1 200	1 200
Төвийн бүс												
ГС	1 400	1 650	1 800	3 000	3 000	3 000	500	650	800	600	850	900
ДА	1 500	1 750	1 700	4 500	4 500	4 500	400	500	600	800	800	1 000
ДО	1 400	1 700	1 600	4 000	4 500	4 500	500	625	733	800	750	1 000
ДУ	1 440	1 720	1 550	4 200	3 900	3 700	700	733	770	800	650	800
ӨМ	1 500	1 800	1 767	4 200	4 000	4 500	1 200	1 000	1 000	1 200	1 000	1 200
СЭ	1 300	1 700	1 600	3 800	4 000	4 200	400	500	600	1 200	1 700 #	1 500
ТӨ	1 500	1 850	1 650	4 750	4 500	4 200	700	700	800	750	800	800
Зүүн бүс												
ДД	1 500	1 700	1 600	3 000	3 500	3 500	600	600	600	700	800	700
СҮ	1 430	1 800	1 500	3 600	3 500	3 500	550	700	700	650	700	700
ХЭ	1 420	1 800	1 600	3 800	5 000	4 000	700	800	800	800	1 000	750
Улаанбаатар												
УБ	1 503	1 775	1 680	4 320	4 290	4 205	853	960	960	816	945	960

1 - Монгол сонгино



ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сараар

Аймаг, нийслэл	1 ширхэгийн дундаж үнэ						төг
	Үхрийн шир						
	2 м-ээс доош урттай			2 м-ээс дээш урттай			
	2010 XI	2011 X	2011 XI	2010 XI	2011 X	2011 XI	
	Баруун бүс						
БӨ	14 000	26 500	21 000	14 000	30 000	25 000	
ГО	8 000	15 000	15 000	12 000	25 000	25 000	
ЗА	16 000	20 000	24 000	-	35 000	31 700	
УВ	15 000	18 000	20 000	18 000	20 000	22 000	
ХО	-	-	-	15 000	23 000	22 000	
	Хангайн бүс						
АР	14 000	28 000	28 000	23 000	40 000	40 000	
БХ	10 000	20 000	25 000	15 000	23 000	28 000	
БУ	11 000	23 500	26 000	21 000	33 500	36 000	
ОР	10 500	26 500	26 500	20 800	39 000	40 000	
ӨВ	-	-	-	16 000	25 000	28 000	
ХӨ	12 000	-	26 000	15 000	-	33 000	
	Төвийн бүс						
ГС	11 000	25 000	25 000	-	30 000	30 000	
ДА	9 500	26 000	31 000	20 000	35 000	38 000	
ДУ	10 000	-	-	15 000	-	27 000	
ӨМ	10 000	20 000	20 000	-	-	-	
СЭ	14 000	20 000	25 000	25 000	35 000	35 000	
ТӨ	10 000	22 000	25 000	16 000	28 000	40 000	
	Зүүн бүс						
ДД	10 000	24 700	25 000	13 000	30 000	28 000	
СҮ	-	23 500	23 500	-	35 000	32 500	
ХЭ	12 000	30 000	30 000	-	-	-	
	Улаанбаатар						
УБ	14 000	30 000	29 000	26 000	39 000	39 000	

Аймаг, нийслэл	1 ширхэгийн дундаж үнэ		
	Адууны шир		
	2010 XI	2011 X	2011 XI
	Баруун бүс		
БӨ	23 000	30 000	37 000
ГО	20 000	30 000	32 000
ЗА	20 000	-	32 000
УВ	18 000	30 000	30 000
ХО	18 000	20 000	22 000
	Хангайн бүс		
АР	24 000	33 000	37 000
БХ	22 000	28 000	32 000
БУ	19 000	28 500	28 500
ОР	17 500	26 000	25 000
ӨВ	25 000	32 000	38 000
ХӨ	15 000	-	35 000
	Төвийн бүс		
ГС	18 000	29 000	35 000
ДА	16 000	27 000	32 000
ДО	22 000	-	-
ДУ	24 000	30 000	38 000
ӨМ	20 000	30 000	34 000
СЭ	22 000	26 000	32 000
ТӨ	22 000	30 000	40 000
	Зүүн бүс		
ДД	15 000	29 500	29 500
СҮ	-	27 500	32 500
ХЭ	18 000	33 000	40 000
	Улаанбаатар		
УБ	23 000	33 000	37 000



Аймаг, нийслэл	1 кг-ын дундаж үнэ Ямааны ноолуур					
	Цагаан			Бор		
	2010 XI	2011 X	2011 XI	2010 XI	2011 X	2011 XI
	Баруун бүс					
БӨ	45 000	51 000	45 000	45 000	51 000	45 000
ГО	45 000	55 000	50 000	45 000	55 000	50 000
ЗА	-	56 500	50 000	-	56 500	-
УВ	46 000	55 000	55 000	45 000	53 000	53 000
ХО	45 700	55 000	-	-	50 000	-
	Хангайн бүс					
АР	45 000	52 000	52 000	45 000	52 000	52 000
БХ	48 000	55 000	50 000	-	55 000	48 000
БУ	-	-	-	42 000	-	-
ОР	43 500	50 000	50 500	41 500	50 000	50 500
ӨВ	48 000	56 000	48 000	48 000	56 000	48 000
ХӨ	45 000	-	49 000	48 000	-	50 000
	Төвийн бүс					
ГС	45 000	-	-	-	-	-
ДА	40 000	50 000	50 000	40 000	50 000	-
ДО	45 000	52 000	40 000	45 000	52 000	40 000
ДУ	-	52 000	45 000	-	-	-
ӨМ	46 000	57 000	50 000	45 000	57 000	50 000
СЭ	-	50 000	-	-	50 000	-
ТӨ	46 200	-	-	46 200	-	-
	Зүүн бүс					
СҮ	40 000	-	-	40 000	-	-
	Улаанбаатар					
УБ	48 000	56 000	52 000	48 000	-	-

Аймаг, нийслэл	1 ширхэгийн дундаж үнэ					
	Хонины /ноостой/ нэхий, ширхэг			Ямааны /ноолууртай/ арьс, ширхэг		
	2010 XI	2011 X	2011 XI	2010 XI	2011 X	2011 XI
	Баруун бүс					
БӨ	6 500	10 000	12 000	20 000	13 500	16 700
ГО	9 300	-	-	19 000	13 800	-
ЗА	9 700	18 000	16 000	18 000	-	16 000
УВ	8 000	16 000	12 500	17 000	11 000	14 000
ХО	10 500	17 000	16 000	19 500	13 000	17 000
	Хангайн бүс					
АР	9 000	-	-	16 000	10 000	14 000
БХ	10 000	18 000	15 000	19 000	12 000	17 000
БУ	6 800	15 000	15 500	15 000	-	-
ОР	8 000	15 000	15 000	11 500	-	-
ӨВ	11 500	17 000	18 000	19 500	13 000	18 000
ХӨ	9 000	-	18 000	15 000	-	15 000
	Төвийн бүс					
ГС	9 000	14 500	14 700	18 000	13 000	16 500
ДА	9 000	16 000	15 000	18 000	13 000	17 000
ДО	9 000	16 000	12 000	15 000	14 000	13 000
ДУ	10 000	18 000	18 000	20 000	15 000	18 000
ӨМ	9 000	15 000	16 000	18 000	14 000	17 500
СЭ	8 500	13 000	14 500	17 000	-	15 000
ТӨ	10 000	15 000	15 000	-	-	17 000
	Зүүн бүс					
ДД	6 300	12 000	11 500	13 000	12 000	13 000
С?	-	-	11 000	-	-	17 000
ХЭ	7 000	-	12 000	12 000	-	17 000
	Улаанбаатар					
УБ	8 000	13 000	12 000	16 000	12 000	15 000

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА**

(жил бүрийн эхний 11 сарын байдлаар, оны үнээр)

	сая төг			
	2010 I-XI	дүнд эзлэх хувь	2011 I-XI	дүнд эзлэх хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2 643 240.3	100.0	3 860 225.0	100.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	-	-	138 803.3	3.6
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2 643 240.3	100.0	3 721 421.7	96.4
УРСГАЛ ОРЛОГО	2 602 793.6	98.5	3 705 195.3	96.0
ТАТВАРЫН ОРЛОГО	2 320 435.1	87.8	3 298 859.8	85.5
1. Орлогын албан татвар	846 895.0	32.0	743 867.0	19.3
- Аж ахуйн нэгжийн	338 681.3	12.8	490 505.3	12.7
- Хүн амын	134 056.7	5.1	197 547.2	5.1
- Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн	374 157.0	14.2	55 814.5	1.4
2. Нийгмийн даатгалын шимтгэл	274 720.2	10.4	391 315.0	10.1
3. Өмчийн татвар	10 776.8	0.4	14 059.7	0.4
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	757 992.0	28.7	1 279 129.5	33.1
- Нэмэгдсэн өртгийн татвар	498 168.3	18.8	992 722.4	25.7
- Онцгой албан татвар	243 050.0	9.2	261 666.5	6.8
- Тусгай зориулалтын орлого	16 773.7	0.6	24 740.7	0.6
5. Гадаад худалдааны татварын орлого	168 958.6	6.4	299 698.5	7.8
6. Бусад татвар	261 092.4	9.9	570 790.1	14.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	282 358.5	10.7	406 335.5	10.5
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	5 885.2	0.2	14 684.7	0.4
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	34 561.4	1.3	1 541.8	0.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2 572 195.6	100.0	3 813 308.7	100.0
НИЙТ ЗАРЛАГА	2 348 386.8	91.3	3 525 583.8	92.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1 933 807.1	75.2	2 776 596.5	72.8
1. Бараа, үйлчилгээний зардал	985 814.1	38.3	1 256 977.3	33.0
- Цалин, хөлс	568 521.1	22.1	711 077.4	18.6
- Нийгмийн даатгалын шимтгэл	52 994.3	2.1	65 236.5	1.7
- Бараа, үйлчилгээний бусад зардал	417 293.0	16.2	545 899.9	14.3
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	40 452.4	1.6	34 415.1	0.9
3. Татаас ба шилжүүлэг	907 540.6	35.3	1 485 204.1	38.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	414 579.7	16.1	748 987.3	19.6
Дотоод эх үүсвэр	402 787.8	15.7	702 780.4	18.4
- Хөрөнгө оруулалт	361 297.5	14.0	633 146.4	16.6
- Их засварын зардал	20 699.0	0.8	42 788.5	1.1
- Авто замын сан	8 839.6	0.3	-	-
- Геологи хайгуулын зардал	2 552.1	0.1	3 006.1	0.1
- Ойжуулалт, байгаль орчны бусад арга хэмжээ	3 935.8	0.2	3 609.9	0.1
- Улсын нөөц бүрдүүлэх зардал	5 463.8	0.2	20 229.5	0.5
Гадаад эх үүсвэр	11 791.9	0.5	46 207.0	1.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	223 808.8	8.7	287 724.8	7.5
- Гадаад зээлээр санхүүжих төсөл	56 350.3	2.2	12 625.4	0.3



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА
(жил бүрийн эхний 11 сарын байдлаар, оны үнээр)

Аймаг, нийслэл	Орлого			Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг		Зарлага		
	2010 I-XI	2011 I-XI	$\frac{2011 \text{ I-XI}}{2010 \text{ I-XI}}$ %	2010 I-XI	2011 I-XI	2010 I-XI	2011 I-XI	$\frac{2011 \text{ I-XI}}{2010 \text{ I-XI}}$ %
Бүгд	303 911.4	503 473.0	165.7	18 315.7	29 439.9	288 257.6	401 960.0	139.4
	Баруун бүс							
Дүн	21 016.6	32 240.4	153.4	7 912.7	13 145.1	20 498.5	30 293.3	147.8
БӨ	3 604.5	5 337.1	148.1	1 420.0	2 345.1	3 673.0	5 111.2	139.2
ГО	4 547.0	7 260.3	159.7	732.8	1 069.8	3 898.4	6 295.2	161.5
ЗА	4 308.3	6 477.0	150.3	1 967.7	3 550.3	4 735.5	6 266.1	132.3
УВ	4 226.8	6 733.9	159.3	2 168.7	3 763.8	3 613.5	6 556.1	181.4
ХО	4 330.0	6 432.1	148.5	1 623.5	2 416.1	4 578.2	6 064.6	132.5
	Хангайн бүс							
Дүн	60 297.4	97 911.5	162.4	9 234.4	13 724.0	59 082.5	81 550.2	138.0
АР	4 359.5	6 478.5	148.6	2 006.4	3 068.4	4 326.4	5 684.7	131.4
БХ	4 851.3	6 722.1	138.6	2 092.5	3 032.9	4 472.1	6 076.3	135.9
БУ	4 300.3	5 676.1	132.0	-	-	3 987.7	5 267.0	132.1
ОР	36 237.0	63 775.3	176.0	-	-	35 744.3	50 539.5	141.4
ӨВ	5 068.4	7 180.3	141.7	2 378.7	3 411.0	5 196.8	6 627.3	127.5
ХӨ	5 481.0	8 079.2	147.4	2 756.8	4 211.7	5 355.3	7 355.3	137.3
	Төвийн бүс							
Дүн	69 274.3	141 174.3	203.8	1 168.6	2 570.9	65 798.6	119 250.5	181.2
ГС	1 975.5	2 594.9	131.4	217.6	551.6	1 786.3	2 682.9	150.2
ДА	6 685.5	8 760.3	131.0	-	-	5 865.8	9 019.9	153.8
ДО	7 206.5	11 789.3	163.6	-	-	6 740.0	10 885.4	161.5
ДУ	3 192.3	4 552.0	142.6	951.0	2 019.3	2 974.3	4 360.4	146.6
ӨМ	32 362.6	92 671.3	286.4	-	-	31 205.9	72 616.9	232.7
СЭ	12 291.8	12 053.2	98.1	-	-	11 551.2	10 487.8	90.8
ТӨ	5 560.1	8 753.2	157.4	-	-	5 675.1	9 197.2	162.1
	Зүүн бүс							
Дүн	15 992.2	20 612.5	128.9	-	-	14 789.0	19 662.6	133.0
ДД	4 263.3	7 356.3	172.5	-	-	3 642.9	6 471.9	177.7
СҮ	6 814.0	6 558.4	96.2	-	-	6 173.3	7 510.9	121.7
ХЭ	4 914.9	6 697.8	136.3	-	-	4 972.7	5 679.8	114.2
	Улаанбаатар							
Дүн	137 330.9	211 534.3	154.0	-	-	128 089.0	151 203.5	118.0
УБ	137 330.9	211 534.3	154.0	-	-	128 089.0	151 203.5	118.0

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО
(жил бүрийн эхний 11 сарын байдлаар, оны үнээр)

Аймаг, нийслэл	2010 I-XI	2011 I-XI	сая төг	
			$\frac{2011 \text{ I-XI}}{2010 \text{ I-XI}}$ %	
Бүгд	112 085.9	118 287.3	105.5	
ГС	19.6	-	-	
ДА	2 274.4	2 478.6	109.0	
ДО	3 000.0	2 546.1	84.9	
ДД	-	924.3	-	
ОР	29 524.8	42 600.0	144.3	
ӨМ	23 000.0	47 772.0	207.7	
ХЭ	334.1	218.2	65.3	
СЭ	3 774.4	850.0	22.5	
УБ	50 158.6	20 898.1	41.7	



**Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, дэд салбараар,
жил бүрийн эхний 11 сарын байдлаар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр**

Аж үйлдвэрийн салбар	2010 XI	2011 XI	2010 I-XI	2011 I-XI	сая төг
					$\frac{2011 \text{ I-XI}}{2010 \text{ I-XI}} \%$
Нийт дүн	168 094.7	190 915.0	1 685 488.6	1 860 856.5	110.4
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	98 443.7	112 162.7	992 018.7	1102 043.8	111.1
Нүүрс олборлолт	33 551.1	38 825.4	235 045.5	290 896.3	123.8
Газрын тос олборлолт	9 653.6	16 240.2	109 558.7	122 822.8	112.1
Металлын хүдэр олборлолт	53 314.9	55 509.6	622 847.3	666 377.4	107.0
Бусад ашигт малтмал олборлолт	1 924.1	1 587.6	24 567.1	21 947.2	89.3
Боловсруулах аж үйлдвэр	48 763.8	55 581.6	503 414.7	558 477.9	110.9
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	25 856.7	30 179.1	250 177.0	276 064.7	110.3
Тамхи үйлдвэрлэл	2 703.3	2 916.6	17 968.1	22 697.2	126.3
Нэхмэлийн үйлдвэрлэл	7 855.1	6 299.0	94 114.2	95 698.8	101.7
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	923.4	764.1	6 325.2	11 698.9	185.0
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	33.4	742.1	3 808.3	3 618.6	95.0
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	290.1	180.2	2 602.1	2 580.1	99.2
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	168.9	287.6	2 163.0	2 635.7	121.9
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	760.4	906.4	10 534.2	8 952.5	85.0
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш үйлдвэрлэл	35.9	49.8	265.3	368.4	138.9
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 613.6	2 065.5	14 406.0	20 867.2	144.9
Резин болон хуванцар бүтээгдэхүүн	61.4	46.8	445.9	779.2	174.7
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	3 512.9	4 757.0	34 556.1	51 680.8	149.6
Төмрийн үйлдвэрлэл	4 803.5	6 029.6	63 998.6	55 894.1	87.3
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	2.1	1.7	41.8	34.4	82.4
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	24.3	22.2	235.4	774.9	329.2
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	36.0	268.9	362.5	3 216.5	887.3
Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл, цаг үйлдвэрлэл	1.4	0.4	320.1	68.7	21.5
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	-	-	58.0	-	-
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	81.4	64.5	1 033.0	847.3	82.0
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	20 887.2	23 170.7	190 055.2	200 334.7	105.4
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	19 755.9	22 003.7	177 626.7	187 889.4	105.8
Ус ариутгал, усан хангамж	1 131.3	1 167.0	12 428.6	12 445.3	100.1



**Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
жил бүрийн эхний 11 сарын байдлаар**

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2010 XI	2011 XI	2010 I-XI	2011 I-XI	<u>2011 I-XI</u> <u>2010 I-XI</u> %
Цахилгаан эрчим хүч	сая кВт.цаг	336.1	381.8	3 274.8	3 488.7	106.5
Дулааны эрчим хүч	мян.Гкал	949.5	1 007.5	6 836.3	7 065.5	103.4
Газрын тос	мян.баррел	176.4	296.8	2 002.4	2 244.8	112.1
Нүүрс	мян.т	3 202.3	3 705.7	22 434.0	27 764.7	123.8
Зэсийн баяжмал, 35%-ийн агуулгад шилжүүлснээр	мян.т	29.4	28.8	327.5	317.9	97.1
Молибдений баяжмал, 47%- ийн агуулгад шилжүүлснээр	т	363.2	333.3	4 274.5	3 759.3	87.9
Хайлуур жоншны баяжмал	мян.т	10.4	7.7	130.0	116.0	89.2
Алт	кг	439.5	475.7	5 792.2	5 483.3	94.7
Катодын зэс, 99%	т	219.9	224.0	2 506.7	2 205.2	88.0
Сүлжмэл эдлэл	мян.ш	78.4	71.2	654.7	693.9	106.0
Самнасан ноолуур	т	39.8	13.9	811.6	866.1	106.7
Хивс	мян.м ²	75.6	83.4	550.6	763.8	138.7
Тэмээний ноосон хөнжил	мян.м	2.6	1.2	12.5	21.9	175.2
Зүсмэл материал	м ³	3 523.3	532.6	16 484.7	16 448.3	99.8
Шохой	мян.т	4.2	5.5	45.3	40.8	90.1
Сонин	сая х.д.х	3.1	3.7	39.1	36.9	94.5
Малын мах	т	2 383.2	3 988.8	7 166.9	6 432.4	89.8
Хиамны зүйл	т	151.6	177.5	1 514.9	1 949.8	128.7
Гурил	т	13 695.3	8 548.1	127 364.9	89 489.3	70.3
Талх	т	1 870.3	2 747.6	19 763.4	21 487.4	108.7
Нарийн боов	т	1 125.0	1 245.1	11 664.5	11 815.2	101.3
Гоймон	т	125.6	238.7	1 913.0	2 031.0	106.2
Амтат ус, ундаа	мян.л	3 421.0	7 050.0	61 688.2	72 490.0	117.5
Архи, дарс	мян.л	1 865.9	2 007.1	18 628.6	23 436.9	125.8
Спирт	мян.л	467.9	398.9	3 244.6	3 338.9	102.9



Хавсралт № 9

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, салбараар,
жил бүрийн эхний 11 сарын байдлаар**

сая төг

	2010 I-XI	2011 I-XI	Үүнээс: гадаадад	Дүнд эзлэх хувь	
				2010 I-XI	2011 I-XI
Аж үйлдвэр бүгд	3 930 908.1	5 085 777.5	3 213 728.8	100.0	100.0
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	2 770 470.6	3 348 787.4	2 778 328.8	70.5	65.8
Нүүрс олборлолт	961 102.8	1 282 313.5	1 172 994.1	24.4	25.2
Газрын тос олборлолт	197 867.9	261 640.8	261 640.8	5.0	5.1
Металлын хүдэр олборлолт	1 550 201.3	1 733 277.3	1 284 528.2	39.4	34.1
Бусад ашигт малтмал олборлолт	61 298.6	71 555.9	59 165.7	1.6	1.4
Боловсруулах аж үйлдвэр	844 949.1	1 373 232.8	435 400.0	21.5	27.0
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	441 935.5	593 759.3	6 300.4	11.2	11.7
Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	38 514.9	37 057.4	5 636.8	8.7 *	6.2 *
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	28 184.0	33 252.6	-	6.4 *	5.6 *
Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл	75 724.8	118 689.2	-	17.1 *	20.0 *
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	56 213.0	63 557.7	-	12.7 *	10.7 *
Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	243 298.9	341 202.4	663.7	55.1 *	57.5 *
Тамхи үйлдвэрлэл	35 461.4	38 690.6	-	0.9	0.8
Нэхмэлийн үйлдвэрлэл	134 193.0	167 814.7	109 459.9	3.4	3.3
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	7 528.5	10 339.9	542.8	0.2	0.2
Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл	1 366.1	2 058.9	387.4	0.0	0.0
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	7 517.2	8 411.1	-	0.2	0.2
Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа	14 246.5	14 584.5	-	0.4	0.3
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	9 589.2	10 545.5	-	0.2	0.2
Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш үйлдвэрлэл	167.0	274 825.0	274 356.1	0.0	5.4
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	24 511.6	38 814.9	-	0.6	0.8
Резин болон хуванцар бүтээгдэхүүн	564.7	2 975.9	-	0.0	0.1
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	54 655.5	103 385.0	-	1.4	2.0
Төмрийн үйлдвэрлэл	96 776.0	81 061.6	44 079.1	2.5	1.6
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	11 454.6	20 266.9	270.8	0.3	0.4
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	155.2	1 303.2	-	0.0	0.0
Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл	1 058.3	846.2	-	0.0	0.0
Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл, цаг үйлдвэрлэл	546.0	224.7	-	0.0	0.0
Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл	2 310.1	2 000.0	-	0.1	0.0
Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад	912.8	1 325.0	3.6	0.0	0.0
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	315 488.4	363 757.3	-	8.0	7.2
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	285 533.5	328 474.6	-	7.3	6.5
Ус ариутгал, усан хангамж	29 954.9	35 282.7	-	0.8	0.7

Тайлбар: * Бүлгийн дүнд эзлэх хувь



**Төмөр зам, агаарын тээврийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн
эхний 11 сарын байдлаар**

Тээврийн төрөл, үзүүлэлтүүд	2009 I-XI	2010 I-XI	2011 I-XI	$\frac{2011 \text{ I-XI}}{2010 \text{ I-XI}}$ %
I. Төмөр замын тээвэр				
Тээсэн ачаа, мян.т	12 819.8	15 282.6	16 783.2	109.8
дотоодын	6 933.9	7 543.9	7 911.4	104.9
гаргалт	2 637.9	4 160.3	5 297.8	127.3
оруулалт	1 136.6	1 418.8	1 807.3	127.4
дамжин өнгөрөх	2 111.4	2 159.5	1 766.7	81.8
Ачаа эргэлт, сая т.км	7 094.5	9 386.1	10 389.5	110.7
дотоодын	2 138.6	2 400.6	2 696.1	112.3
гаргалт	2 084.4	3 889.1	4 793.3	123.3
оруулалт	527.9	699.3	939.0	134.3
дамжин өнгөрөх	2 343.6	2 397.1	1 961.0	81.8
Зорчигчдын тоо, мян.хүн	2 863.4	3 239.5	3 540.0	109.3
олон улсад зорчсон	119.2	133.8	154.6	115.5
дотоодод зорчсон	2 744.2	3 105.6	3 385.4	109.0
Зорчигч эргэлт, сая хүн км	928.2	1 120.4	1 284.3	114.6
Шилжүүлсэн сая т.км	8 022.7	10 506.5	11 673.7	111.1
Тээврийн орлого, оны үнээр, сая төг	204 660.4	271 446.6	354 084.7	130.4
II. Агаарын тээвэр				
Тээсэн ачаа, т	1 234.6	1 504.5	2 580.7	171.5
шуудан	284.3	343.4	387.6	112.9
тээш	326.5	251.5	358.0	142.4
ачаа	623.8	909.7	1 835.1	201.7
Ачаа эргэлт, мян.т.км	3 381.5	3 917.3	6 771.1	172.8
шуудан	638.0	595.8	705.8	118.5
тээш	540.0	359.3	503.4	140.1
ачаа	2 203.4	2 962.1	5 561.9	187.8
Зорчигчдын тоо, мян.хүн	286.9	364.7	525.5	144.1
олон улсад зорчсон	219.1	253.3	348.4	137.5
дотоодод зорчсон	67.7	111.4	177.1	159.0
Зорчигч эргэлт, сая хүн км	598.5	618.2	894.4	144.7
Шилжүүлсэн сая т.км	57.7	60.1	88.0	146.5
Тээврийн орлого, оны үнээр, сая төг	103 672.3	105 714.4	149 913.5	141.8



Хавсралт № 11

Гадаад худалдааны нийт эргэлт, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

Үзүүлэлт	2010 I-XI	2011 I-XI	мян.ам.долл
			$\frac{2011 \text{ I-XI}}{2010 \text{ I-XI}}\%$
Нийт бараа эргэлт	5 421 753.3	10 271 184.2	189.4
Экспорт	2 550 648.2	4 303 877.1	168.7
Валютын төлбөртэй худалдаа	2 547 288.0	4 297 963.3	168.7
Гадаадын тусламжийн бараа	-	316.3	-
Гадаадын захиалагчийн материалаар хийсэн бараа	606.9	1 703.9	280.8
Бусад	2 753.3	3 893.6	141.4
Импорт	2 871 105.1	5 967 307.1	207.8
Валютын төлбөртэй худалдаа	2 632 981.9	4 713 797.8	179.0
Бараа солилцоо	3 877.4	356.2	9.2
Гадаадын тусламжийн бараа	95 894.8	131 603.9	137.2
Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа	121 897.1	1 117 905.1	917.1
Гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа	14 745.8	2 497.7	16.9
Гадаадын захиалагчийн материал, эд зүйлс	765.1	576.8	75.4
Бусад	943.0	569.6	60.4

Хавсралт № 12

Экспорт, импорт, барааны бүлгээр, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

Барааны бүлэг	2010 I-XI		2011 I-XI	
	Дүн	Дүнд эзлэх хувь	Дүн	Дүнд эзлэх хувь
Экспорт	2 550 648.2	100.0	4 303 877.1	100.0
Эрдэс бүтээгдэхүүн	2 045 121.8	80.2	3 785 091.2	87.9
Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн	206 142.9	8.1	231 583.9	5.4
Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	165 209.6	6.5	147 402.7	3.4
Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	31 130.9	1.2	45 666.2	1.1
Мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн	49 857.8	2.0	32 917.4	0.8
Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	18 976.3	0.7	22 358.2	0.5
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг	9 513.1	0.4	11 297.0	0.3
Бусад	24 695.9	0.9	27 560.5	0.6
Импорт	2 871 105.1	100.0	5 967 307.1	100.0
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг	608 421.8	21.2	1 637 377.6	27.4
Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	514 053.7	17.9	1 376 083.4	23.1
Эрдэс бүтээгдэхүүн	687 082.7	23.9	1 119 432.0	18.8
Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	184 768.5	6.4	551 058.2	9.2
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	212 297.3	7.4	300 759.0	5.0
Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн	186 922.6	6.5	230 068.9	3.9
Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл	99 822.6	3.5	212 187.5	3.6
Чулуу, гөлтөнө, цемент, шөрмөсөн чулуун зүйлс, шил, шилэн сав	53 928.6	1.9	101 301.5	1.7
Үйлдвэрийн төрөл бүрийн бараа	48 565.3	1.7	89 065.8	1.5
Бусад	275 241.8	9.6	349 973.1	5.8



Хүүхдийн хоол тэжээлийн хангамж ба эрүүл мэнд

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь Хүүхэд хөгжил буюу Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа (ОУБТС)-г Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хүүхдийн сан (НҮБХС)-гийн дэмжлэгтэйгээр 1996, 2000, 2005 онд олон улсын жишиг, аргачлалын дагуу явуулж, үр дүнг үндэсний хэмжээнд болон олон улсын түвшинд танилцуулж байсан.

Монгол Улсын Засгийн газраас 2002 онд баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хугацаа 2010 онд дууссантай холбогдуулан хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд хүүхдийн нөхцөл байдлын талаарх дэлгэрэнгүй тоо мэдээлэл зайлшгүй шаардлагатай юм.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар болон НҮБХС-гийн дэмжлэгтэйгээр хүүхдийн хөгжил, хамгаалалтай холбоотой дэлхийн тунхаглал болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах, дүгнэлт гаргахад шаардлагатай хүүхдийн хооллолт, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, аж байдал болон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн боловсрол, гэр бүлийн байдал, ХДХВ/ДОХ-ын халдварын талаарх мэдлэг, бэлгийн харьцааны төлөвшил зэрэг чухал асуудлаар статистикийн тоо мэдээллийг гаргах, өмнөх судалгааны мэдээллийг шинэчлэх, баяжуулах зорилгоор 2010 онд “Хүүхэд хөгжил” судалгааг 4 дэх удаагаа зохион байгууллаа.

Энэхүү судалгаа нь дэлхийн улс орнуудад нэг ижил хугацаанд, нэгдсэн арга зүйгээр явагддагаараа онцлог бөгөөд судалгааны үр дүн нь бүсийн түвшинд нэгтгэгдэн гардаг.

Хүүхэд хөгжил судалгаа нь өрхөд суурилсан судалгаа бөгөөд 2010 оны судалгаагаар 21 аймаг, Улаанбаатар хотын нийт 10092 өрхөөс мэдээлэл цуглуулсан юм.

Энэхүү танилцуулгад 2005, 2010 оны “Хүүхэд хөгжил” судалгааны дүнд үндэслэн хүүхдийн хоол тэжээлийн хангамж, хөхөөр хооллолт, А аминдэмийн хэрэглээ, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүүхдийн хувь, хүүхдийн өвчлөлийн түвшинг харьцууллаа.

Хоол тэжээлийн хангамж. Хоол тэжээлийн байдлын гурван шалгуур үзүүлэлтийг тав хүртэлх насны хүүхдийн өсөлт, хөгжилтийн хэвийн байдлыг үнэлэх өндөр, жингийн тархалтын стандарт¹ голч утгаас хэлбэлзэх хазайлтаар тодорхойлдог.

Тухайн насны хүүхдийн биеийн жин нь стандарт жингийн голчоос хэлбэлзэх стандарт хазайлтыг (СХ) 2 дахин авснаас доогуур байвал дунд зэргийн, стандарт хазайлтыг 3 дахин авснаас доогуур байвал тураалын хүнд хэлбэр гэж үздэг. “Хүүхэд хөгжил – 2005” судалгааны дүнгээр тав хүртэлх насны хүүхдийн 6.3 хувь нь дунд хэлбэрийн тураалтай, 1.1 хувь нь хүнд хэлбэрийн тураалтай гэсэн дүн гарчээ. Хөдөөгийн тав хүртэлх насны хүүхдүүдийн 7.0 хувь нь дунд хэлбэрийн тураалтай, харин хотын хүүхдүүдийн 5.6 хувь нь дунд хэлбэрийн тураалтай байв.

Тав хүртэлх насны хүүхдийн 20.9 хувийнх нь өндрийн хэмжээ стандарт өндрийн голчоос хэлбэлзэх стандарт хазайлтыг 2 дахин авснаас доогуур буюу дунд хэлбэрийн өсөлтийн хоцролттой, 5.9 хувь нь стандарт хазайлтыг 3 дахин авснаас доогуур буюу өсөлтийн хоцролтын хүнд хэлбэртэй байжээ. Энэ нь хот, хөдөөд харилцан адилгүй байгаа нь Хүснэгт 1-ээс харагдаж байна.

Тав хүртэлх насны хүүхдүүдийн 2.2 хувь нь тухайн өндөрт байвал зохих биеийн жин нь стандарт жингийн голчоос хэлбэлзэх стандарт хазайлтыг 2 дахин авснаас доогуур буюу дунд хэлбэрийн туранхай, 0.6 хувь нь хүнд хэлбэрийн туранхай байна.

¹ НҮБ-ын Хүүхдийн сан, ДЭМБ-аас зөвлөмж болгосон ДЭМБ/АНУ-ын Эрүүл мэндийн Статистикийн үндэсний төвийн боловсруулсан стандарт



0-59 сартай, хоол, тэжээлийн дуталтай хүүхдийн хувийн жин

Хүснэгт 1

хувь

		Тухайн насны жингээс				Тухайн насны өндрөөс				Тухайн өндрийн жингээс			
		% доогуур -2 СХ		% доогуур -3 СХ		% доогуур -2 СХ		% доогуур -3 СХ		% доогуур -2 СХ		% доогуур -3 СХ	
		2005	2010	2005	2010	2005	2010	2005	2010	2005	2010	2005	2010
Хүйсээр	Эрэгтэй	5.9	4.9	1.2	2.5	21.5	17.5	5.9	6.1	1.9	2.5	0.6	1.4
	Эмэгтэй	6.6	4.5	1.0	2.3	20.3	14.2	5.9	4.7	2.4	2.1	0.5	1.4
Хот хөдөөгөөр	Хот	5.6	4.4	0.9	2.3	18.4	12.6	5.0	5.0	2.2	2.6	0.5	1.7
	Хөдөө	7.0	5.1	1.3	2.6	23.6	20.4	6.8	6.0	2.1	1.8	0.6	1.0
Байршил	Нийслэл	5.4	5.0	0.9	2.9	18.2	11.6	5.2	5.4	2.5	3.3	0.7	2.3
	Аймгийн төв	5.9	3.4	0.9	1.3	18.8	14.2	4.8	4.3	1.8	1.6	0.4	.8
	Сумын төв	5.9	4.5	0.6	2.3	24.1	15.5	5.8	4.8	0.6	1.4	0.3	.8
	Хөдөө	7.3	5.5	1.5	2.8	23.4	23.9	7.1	6.9	2.6	2.1	0.6	1.1
Бүгд		6.3	4.7	1.1	2.4	20.9	15.9	5.9	5.4	2.2	2.3	0.6	1.4

Эх үүсвэр: Хүүхэд хөгжил судалгаа-2005, 2010

“Хүүхэд хөгжил-2010” судалгааны дүнгээр тав хүртэлх насны хүүхдийн 4.7 хувь нь дунд хэлбэрийн тураалтай гарсан нь 2005 оны судалгааныхаас 1.6 пунктээр доогуур байна. Харин тав хүртэлх насны хүүхдийн 15.9 хувь нь дунд хэлбэрийн өсөлтийн хоцролттой байгаа нь 2005 оны судалгааныхаас 5.0 пунктээр доогуур байна. Түүнчлэн тав хүртэлх насны хүүхдүүдийн 2.3 хувь нь дунд хэлбэрийн туранхай байгаа нь өмнөх судалгааныхаас 0.1 пунктээр дээгүүр байна.

Хөхөөр хооллолт. Эхийн сүүгээр хооллох нь хүүхдийг халдвараас хамгаалж, шим тэжээлт бодисуудаар хангаж байдаг. Мэргэжилтнүүд хүүхдийг төрсний дараах эхний 6 сард нь зөвхөн эхийн сүүгээр, 6 сартайгаас нь эхлэн аюулгүй, тохирсон, зохистой нэмэгдэл хоол өгч, 2 нас хүртэл нь үргэлжлүүлэн эхийн сүүгээр хооллох шаардлагатай гэж зөвлөдөг.

Хүснэгт 2

Эхийн сүүгээр хооллож байгаа хүүхдийн эзлэх хувь

хувь

		Зөвхөн эхийн сүүгээр хооллож байгаа 0-5 сартай хүүхэд		Эхийн сүүгээр хооллож байгаа 12-15 сартай хүүхэд		Эхийн сүүгээр хооллож байгаа 20-23 сартай хүүхэд	
		2005	2010	2005	2010	2005	2010
		Хүйсээр	Эрэгтэй	58.4	61.8	78.5	84.5
	Эмэгтэй	55.9	56.9	86.6	79.3	63.9	64.3
Хот хөдөөгөөр	Хот	55.1	55.3	77.3	80.8	65.1	68.1
	Хөдөө	59.8	65.1	89.0	84.3	64.6	62.9
Байршил	Нийслэл	60.3	52.6	76.7	77.4	69.1	66.6
	Аймгийн төв	46.5	59.8	(78.2)	87.8	60.4	70.8
	Сумын төв	(54.6)	68.9	(*)	80.0	(70.3)	65.0
	Хөдөө	61.3	62.3	90.0	87.5	61.7	61.2
Бүгд		57.2	59.3	82.3	82.1	64.9	66.0

Эх үүсвэр: Хүүхэд хөгжил судалгаа-2005, 2010

Тайлбар: (*) 25 хүртэлх ажиглалт (жигнээгүй) -ад үндэслэн тооцсон

() 25-49 ажиглалт (жигнээгүй) -ад үндэслэн тооцсон

“Хүүхэд хөгжил-2005” судалгааны дүнгээр 0-5 сартай хүүхдүүдийн 57.2 хувь нь, 2010 оны судалгааны дүнгээр 59.3 хувь нь зөвхөн эхийн сүүгээр хооллож байжээ.

Эхийн сүүгээр хооллож байгаа 12-15 сартай хүүхдийн эзлэх хувь 2005 онд 82.3 хувь байсан бол 2010 онд 82.1 хувь болж буурсан байна. Улаанбаатар хотод 2005 онд 12-15 сартай хүүхдийн 76.7 хувь, 2010 онд 77.4 хувь нь эхийн сүүгээр үргэлжлүүлэн хоолложээ.

Харин 2005 оны судалгааны дүнгээр 20-23 сартай хүүхдүүдийн 64.9 хувь нь эхийн сүүгээр хооллож байгаа бол 2010 оны судалгаагаар 66.0 хувь нь эхийн сүүгээр хооллож байна.



А аминдэмийн хэрэглээ. Хүүхдийн эрүүл мэнд болон дархлалын системийн үйл ажиллагаанд А аминдэмийн гүйцэтгэдэг маш чухал үүрэг бол хүүхэд амьдрахад шаардлагатай анхдагч бичил элементүүдийн дутлыг хянах явдал байдаг. 2005 оны судалгаагаар 6-59 сартай нийт хүүхдийн 64.7 хувь нь сүүлийн 6 сард, 16.6 хувь нь сүүлийн 6 сараас өмнө, 4.0 хувь нь хугацаа нь тодорхойгүй ч өндөр тунт А аминдэм уусан байна.

Хүснэгт 3

Сүүлийн 6 сард өндөр тунт А аминдэмийн бэлдмэлийг өндөр тунгаар уусан 6-59 сартай хүүхдийн эзлэх хувь, 2005 он

		Өндөр тунт А аминдэм уусан хүүхдийн хувийн жин			Өндөр тунт А аминдэм уусан эсэхээ мэдэхгүй	Огт уугаагүй
		Сүүлийн 6 сард	Сүүлийн 6 сараас өмнө	Хэзээ уусныг мэдэхгүй	хувь	
Хүйсээр	Эрэгтэй	65.8	15.9	3.6	0.7	13.9
	Эмэгтэй	63.5	17.3	4.4	0.4	14.4
Хот хөдөөгөөр	Хот	69.5	14.1	3.3	0.6	12.6
	Хөдөө	59.6	19.3	4.7	0.6	15.9
Байршил	Нийслэл	73.1	12.2	2.1	0.6	12
	Аймгийн төв	64.7	16.5	4.9	0.6	13.3
	Сумын төв	66.6	19.9	5.2	0.6	7.8
	Хөдөө	57.5	19.1	4.6	0.6	18.2
Нас	6-11 сартай	65.4	3.4	0.5	0.3	30.3
	12-23 сартай	74.1	12.8	1.9	0.3	10.9
	24-35 сартай	63.9	19.1	4.6	0.7	11.6
	36-47 сартай	62.4	20.5	5.3	0.9	10.9
	48-59 сартай	57.3	21.4	6.2	0.6	14.6
Бүгд		64.7	16.6	4.0	0.6	14.2

Эх үүсвэр: Хүүхэд хөгжил судалгаа-2005

Харин “Хүүхэд хөгжил-2010” судалгаагаар хүүхдийн вакцины картанд тэмдэглэснээр 9.6 хувь нь, эхийн хэлснээр 59.2 хувь нь А аминдэмийг уусан бол сүүлийн 6 сард 61.4 хувь нь уг аминдэмийг уусан байна.

Хүснэгт 4

Сүүлийн 6 сард өндөр тунт А аминдэмийн бэлдмэлийг өндөр тунгаар уусан 6-59 сартай хүүхдийн эзлэх хувь, 2010 он

		Өндөр тунт А аминдэм уусан хүүхдийн хувийн жин		Сүүлийн 6 сард өндөр тунт А аминдэмийн бэлдмэлийг уусан хүүхдийн хувийн жин
		Вакцины картаар	Эхийн хэлснээр	хувь
Хүйсээр	Эрэгтэй	9.8	58.8	61.3
	Эмэгтэй	9.4	59.5	61.5
Хот хөдөөгөөр	Хот	9.5	60.6	62.0
	Хөдөө	9.8	57.3	60.6
Байршил	Нийслэл	8.3	60.7	61.7
	Аймгийн төв	11.5	60.4	62.5
	Сумын төв	9.8	60.9	63.4
	Хөдөө	9.8	54.6	58.5
Нас	6-11 сартай	10.1	53.5	56.4
	12-23 сартай	11.2	65.2	66.8
	24-35 сартай	10.8	60.9	63.5
	36-47 сартай	7.4	56.3	58.4
	48-59 сартай	7.8	54.7	57.0
Бүгд		9.6	59.2	61.4

Эх үүсвэр: Хүүхэд хөгжил судалгаа-2010

Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдалт. НҮБ-ын Хүүхдийн Сан болон ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу хүүхэд бүр төрснөөс хойш 11 сар 29 хоног дотор сүрьеэгийн эсрэг (БЦЖ) болон улаанбурханы эсрэг вакцинд нэг удаа, сахуу-хөхүүл ханиад, татран (СХХТ), саагийн эсрэг вакцинд тус бүр 3 удаа хамрагдах ёстой.



Хүүхдэд төрснөөс хойш 24 цагийн дотор хийдэг сүрьеэгийн вакцинд хамрагдалт 2005 онд 97.6 хувьтай байсан бол 2010 онд 97.9 хувь болсон байна.

Улаанбурханы эсрэг вакцинд хамрагдалт бусад вакцинаас харьцангуй доогуур байна. Вакцинд хамрагдвал зохих товллын дагуу хүүхэд бүр 8-11 сартайдаа улаанбурханы эсрэг вакцинд хамрагдах ёстой хэдий ч 2005 онд тухайн насны хүүхдийн зөвхөн 76.1 хувь нь нэг нас хүрэхээсээ өмнө, 88.2 хувь нь судалгааны өмнөх аль нэг хугацаанд хамрагдаж байсан бол 2010 оны судалгаагаар хүүхдүүдийн 86.6 хувь нь нэг нас хүрэхээсээ өмнө, 87.8 хувь нь судалгааны өмнөх аль нэг хугацаанд улаанбурханы эсрэг вакцинд хамрагдаж байжээ.

Сахуу-хөхүүл ханиад-татрангийн I тунд хамрагдалт 2010 оны судалгаагаар 95.5 хувь, II тунд хамрагдалт 94.3 хувь, III тунд хамрагдалт 92.1 хувь болж, 2005 оныхоос 2.9, 0.7 ба 0.1 пунктээр нэмэгдсэн байна.

Саагийн вакцинд хамрагдалтын түвшин 2010 оны судалгааны дүнгээр I тунд 97.6 хувь, II тунд 96.4 хувь, III тунд 93.3 хувь байна. Энэ нь 2005 оны судалгааныхаас 0.3-0.7 пунктээр өссөн үзүүлэлттэй байв.

Хүснэгт 5

Нэг нас хүрэхийн өмнө болон судалгааны өмнөх аль ч хугацаанд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдсан 12-23 сартай хүүхдийн эзлэх хувь
хувь

	Сүрьеэ		Улаанбурхан		Сахуу - хөхүүл ханиад- татран					
					I тун		II тун		III тун	
	2005	2010	2005	2010	2005	2010	2005	2010	2005	2010
Судалгааны өмнөх аль нэг хугацаанд вакцинд хамрагдсан										
Хэлбэр:										
Вакцины картаар	79.7	83.1	73.7	74.6	76.7	81.4	77.6	80.8	76.3	79.1
Эхийн хэлснээр	17.9	14.9	14.5	13.2	16.9	14.2	16.9	13.7	16.9	13.3
Аль аль нь	97.6	97.9	88.2	87.8	93.6	95.6	94.4	94.5	93.2	92.4
Нэг нас хүрэхийн өмнө вакцинд хамрагдсан	97.6	97.9	76.1	86.6	92.6	95.5	93.6	94.3	92.0	92.1

Эх үүсвэр: Хүүхэд хөгжил судалгаа-2005, 2010

Үргэлжлэл

	Саа						Бүх вакцинд хамрагдсан		Хамрагдаагүй	
	I тун		II тун		III тун					
	2005	2010	2005	2010	2005	2010	2005	2010	2005	2010
Судалгааны өмнөх аль нэг хугацаанд вакцинд хамрагдсан										
Хэлбэр:										
Вакцины картаар	79.8	84.0	78.8	83.8	76.3	81.8	67.4	67.5	0.0	0.0
Эхийн хэлснээр	17.9	13.7	17.9	12.8	17.9	12.0	14.3	9.8	1.5	0.2
Аль аль нь	97.6	97.7	96.7	96.6	94.2	93.8	81.7	77.4	1.5	0.2
Нэг нас хүрэхийн өмнө вакцинд хамрагдсан	97.1	97.6	95.7	96.4	93.0	93.3	67.5	75.7	1.5	0.2

Эх үүсвэр: Хүүхэд хөгжил судалгаа-2005, 2010

Нэг нас хүрэхээсээ өмнө хамрагдвал зохих бүх төрлийн вакцинд хугацаандаа бүрэн хамрагдсан хүүхдийн эзлэх хувь 2010 оны судалгаагаар 75.7 хувь болж, 2005 оныхоос 8.2 пунктээр өссөн байна.

Судалгаанд хамрагдсан 12-23 сартай хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдалтыг вакцины төрлөөр Хүснэгт 6-д үзүүлэв. Хамрагдвал зохих



вакцинд товлोलт хугацаанаас хоцорсон боловч бүх төрлийн вакцинд хамрагдалтын түвшин 2005 онд 81.7 байсан бол 2010 онд 77.4 хувь болж 4.3 пунктээр буурчээ.

Хүснэгт 6

**Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдсан
12-23 сартай хүүхдийн эзлэх хувь**

		Сүрьеэ		Улаанбурхан		Сахуу - хөхүүл ханиад- татран					
						I тун		II тун		III тун	
		2005	2010	2005	2010	2005	2010	2005	2010	2005	2010
Хүйсээр	Эрэгтэй	97.1	98.4	87.1	86.2	93.9	95.6	93.6	94.3	92.1	92.7
	Эмэгтэй	98.2	97.5	89.4	89.3	93.3	95.7	95.3	94.6	94.4	92.2
Хот хөдөөгөөр	Хот	97.9	98.9	89.9	89.4	95.1	96.7	94.8	96.2	94.3	93.7
	Хөдөө	97.3	96.4	86.1	85.2	91.9	94.0	94.0	91.9	91.8	90.4
Байршил	Нийслэл Аймгийн төв	97.8	98.8	92.4	87.9	94.6	96.6	94.2	97.7	94.2	94.9
	Сумын төв	98.1	99.1	86.6	92.2	95.7	96.7	95.7	93.4	94.5	91.5
	Хөдөө	96.6	96.6	84.1	84.7	93.1	96.4	93.1	93.5	89.6	91.8
Бүгд		97.6	97.9	88.2	87.8	93.6	95.6	94.4	94.5	93.2	92.4

Эх үүсвэр: Хүүхэд хөгжил судалгаа-2005, 2010

Үргэлжлэл

		Саа						Бүх вакцинд хамрагдсан		Хамрагдаагүй	
		I тун		II тун		III тун					
		2005	2010	2005	2010	2005	2010	2005	2010	2005	2010
Хүйсээр	Эрэгтэй	97.4	97.7	95.5	96.1	92.9	94.0	80.8	77.7	1.8	0.5
	Эмэгтэй	97.9	97.8	97.9	97.1	95.6	93.6	82.7	77.1	1.2	0.0
Хот хөдөөгөөр	Хот	97.9	97.8	96.6	97.7	94.9	94.5	84.5	80.0	1.3	0.1
	Хөдөө	97.3	97.7	96.7	95.0	93.4	92.7	78.3	73.3	1.8	0.4
Байршил	Нийслэл Аймгийн төв	97.3	97.8	96.4	98.9	95.5	95.1	87.9	80.2	1.8	0.0
	Сумын төв	98.8	97.6	96.9	95.4	93.9	93.5	79.9	79.6	0.6	0.3
	Хөдөө	96.6	98.4	95.4	96.4	89.8	93.3	73.8	73.3	2.3	0.5
Бүгд		97.6	97.1	97.2	93.9	94.7	92.1	80.0	73.2	1.6	0.3
Бүгд		97.6	97.7	96.7	96.6	94.2	93.8	81.7	77.4	1.5	0.2

Эх үүсвэр: Хүүхэд хөгжил судалгаа-2005, 2010

Хүүхдийн өвчлөл. Суулгалт өвчин нь дэлхийн хэмжээнд тав хүртэлх насны хүүхдийн нас баралтын зонхилох шалтгааны нэг болж байгаа бөгөөд суулгалтаас шалтгаалсан нас баралтын ихэнх нь хүүхэд их хэмжээгээр шингэн алдсанаас тохиолддог байна.

2010 оны судалгаанд хамрагдсан тав хүртэлх насны хүүхдүүдийн 10.4 хувь нь сүүлийн хоёр долоо хоногт суулгалт өвчнөөр өвдсөн нь 2005 оныхоос 3.8 пунктээр өссөн байна. Энэ өвчнөөр өвчилсэн хүүхдүүдийн 61.6 хувь нь шингэн сэлбэх ямар нэг эмчилгээ (шингэн сэлбэх давсны ууталсан бэлдмэл, гэрийн нөхцөлд бэлтгэсэн уусмал) хийлгэсэн байхад 38.4 хувь нь огт хийлгээгүй байна.

2010 оны судалгаагаар 5 хүртэлх насны нийт хүүхдийн 1.3 хувьд нь хэвийн хэмжээнээс маш бага, 11.1 хувьд нь хэвийн хэмжээнээс бага зэрэг, 43.6 хувьд нь хэвийн хэмжээнд, 42.6 хувьд нь хэвийн хэмжээнээс илүү шингэн өгсөн бол 0.4 хувьд нь огт шингэн өгөөгүй байна.



Сүүлийн 2 долоо хоногт суулгалт өвчнөөр өвчилсөн үедээ шингэнийг их хэмжээгээр ууж, үргэлжлүүлэн хооллосон 0-59 сартай хүүхдийн эзлэх хувь, 2010 он

хувь

		Сүүлийн 2 долоо хоногт суулгалт өвчнөөр өвчилсөн хүүхэд	Суулгалтын үеийн шингэний хэрэглээ				Шингэн зүйл огт өгөөгүй
			Хэвийн хэмжээнээс маш бага шингэн өгсөн	Хэвийн хэмжээнээс бага зэрэг шингэн өгсөн	Хэвийн хэмжээнд шингэн өгсөн	Хэвийн хэмжээнээс илүү шингэн өгсөн	
Хүйсээр	Эрэгтэй	11.1	1.4	10.4	44.5	43.2	0.0
	Эмэгтэй	9.7	1.1	11.9	42.6	42.0	0.9
Хот хөдөөгөөр	Хот	9.3	0.8	8.4	47.8	41.2	0.5
	Хөдөө	12.0	1.8	14.1	39.1	44.2	0.4
Байршил	Нийслэл	6.1	0.0	10.1	52.6	37.3	0.0
	Аймгийн төв	14.5	1.3	7.2	44.6	43.8	0.8
	Сумын төв	12.2	1.0	13.3	34.5	51.2	0.0
	Хөдөө	11.9	2.5	14.6	42.5	38.8	0.6
Нас	0-11 сартай	15.2	0.7	16.1	44.3	37.7	1.3
	12-23 сартай	15.0	1.2	9.3	40.1	47.7	0.0
	24-35 сартай	8.8	2.7	7.0	48.8	41.4	0.0
	36-47 сартай	5.8	1.4	6.1	52.1	38.9	0.0
	48-59 сартай	3.8	0.0	15.5	29.7	50.4	0.0
Бүгд		10.4	1.3	11.1	43.6	42.6	0.4

Эх үүсвэр: Хүүхэд хөгжил судалгаа-2010

Үргэлжлэл

		Суулгалтын үеийн хоолны хэрэглээ					
		Хоолыг маш бага өгсөн	Хоолыг бага зэрэг өгсөн	Хоолыг хэвийн хэмжээнд өгсөн	Хоолыг хэвийн хэмжээнээс их өгсөн	Хоол огт өгөөгүй	Хоолонд орж эхлээгүй
Хүйсээр	Эрэгтэй	3.5	28.0	57.0	5.7	1.3	3.1
	Эмэгтэй	4.7	28.7	55.6	4.6	2.3	2.8
Хот хөдөөгөөр	Хот	4.0	29.5	57.6	3.3	1.2	2.4
	Хөдөө	4.2	27.0	55.0	7.2	2.4	3.6
Байршил	Нийслэл	6.9	26.8	61.4	2.4	0.0	0.0
	Аймгийн төв	1.9	31.3	54.9	3.9	2.0	4.0
	Сумын төв	2.1	29.2	54.7	6.5	3.3	4.2
	Хөдөө	5.7	25.4	55.2	7.7	1.8	3.2
Нас	0-11 сартай	4.2	19.8	53.8	10.0	2.9	9.3
	12-23 сартай	5.5	36.2	52.1	2.0	1.1	0.0
	24-35 сартай	3.0	27.7	64.7	1.9	2.7	0.0
	36-47 сартай	2.8	28.7	60.1	8.4	0.0	0.0
	48-59 сартай	0.0	30.0	63.7	1.9	0.0	0.0
Бүгд		4.1	28.3	56.3	5.2	1.8	3.0

Эх үүсвэр: Хүүхэд хөгжил судалгаа-2010



Манай улс суулгалт өвчний үед хоолыг сойхгүй үргэлжлүүлэн хооллох гэсэн ДЭМБ-ын зөвлөмжийг хэрэгжүүлдэг. “Хүүхэд хөгжил-2010” судалгааны дүнгээр суулгалтаар өвчилсөн хүүхдүүдийн 56.3 хувь нь ердийн үеийнхтэй ойролцоо хэмжээгээр хооллосон байна.

Дүгнэлт

“Хүүхэд хөгжил” судалгааны 2010 оны дүнгээр тав хүртэлх насны хүүхдийн 4.7 хувь нь дунд хэлбэрийн тураалтай, 15.9 хувь нь дунд хэлбэрийн өсөлтийн хоцролттой, 2.3 хувь нь дунд хэлбэрийн туранхай байгаа нь 2005 оны судалгааны дүнгээс дунд хэлбэрийн тураалтай хүүхдийн эзлэх хувь 1.6 пункт, дунд хэлбэрийн өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувь 5.0 пунктээр буурсан боловч харин дунд хэлбэрийн туранхай хүүхдийн эзлэх хувь 0.1 пунктээр нэмэгдсэн байна.

Хүүхдийг эхний 6 сард нь зөвхөн эхийн сүүгээр хооллох нь хүүхдийн эрүүл мэндэд чухал бөгөөд 2010 оны судалгаагаар 0-5 сартай нийт хүүхдийн 59.3 хувь нь зөвхөн эхийн сүүгээр хооллосон нь 2005 оны судалгааныхаас 2.1 пунктээр өсчээ. Хүүхдийг 2 нас хүртэл нь үргэлжлүүлэн эхийн сүүгээр хооллох шаардлагатай бөгөөд 20-23 сартайдаа эхийн сүүгээр хооллож байгаа хүүхдийн эзлэх хувь 2010 оны судалгааны дүнгээр 66.0 болж, 2005 оны судалгааны дүнгээс 1.1 пунктээр өсчээ.

Сүүлийн 6 сард өндөр тунт А аминдэмийн бэлдмэлийг уусан 6-59 сартай хүүхдийн эзлэх хувь 2005 оны судалгаагаар 64.7 хувь байсан бол 2010 онд 61.4 хувь болж, 3.3 пунктээр буурсан байна.

Нэг нас хүрэхийн өмнө буюу хамрагдвал зохих хугацаандаа сүрьеэ, улаанбурхан, сахуу-хөхүүл ханиад-татран, саа зэрэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь 2010 онд 75.7 болж, 2005 оныхоос 8.2 пунктээр өсчээ. Хүүхдийн сахуу-хөхүүл ханиад-татрангийн I, II, III тунт вакцинд хамрагдалт 2010 онд 2005 оноос 0.1-2.9 пунктээр өссөн байна.

“Хүүхэд хөгжил-2010” судалгаанд хамрагдсан тав хүртэлх насны хүүхдүүдийн 10.4 хувь нь сүүлийн хоёр долоо хоногт суулгалт өвчнөөр өвдсөн байгаа нь 2005 оныхоос 3.8 пунктээр дээгүүр байна.



Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм

АНУ-ын эдийн засаг

АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний товчооны урьдчилсан тооцоогоор 2011 оны 11 дүгээр сарын 22-нд мэдээлснээр зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2011 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 2.0 хувиар* өсчээ¹.

Хэрэглээний үнийн индекс 2011 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.1 хувиар* буурч, өмнөх оны мөн үеийнхээс 3.5 хувиар өсчээ².

Гадаад худалдааны алдагдал 2011 оны эхний 9 сард 418.6 тэрбум ам.долл* болж, өмнөх оны мөн үеийнхээс 37.3 тэрбум ам.долл буюу 9.8 хувиар* өсчээ³.

Тус улсын Холбооны нөөцийн сан (Төв банк)-гийн урьдчилсан тооцоогоор аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2011 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 3.9 хувиар өссөн байна⁴.

Ажилгүйдлийн түвшин 2011 оны 11 дүгээр сард 8.6 хувь* болж, өмнөх сарынхаас 0.4 пунктээр буурчээ⁵.

Япон улсын эдийн засаг

Япон улсын Эдийн засаг, нийгмийн судалгааны институтийн урьдчилсан тооцоогоор 2011 оны 11 дүгээр сарын 14-нд мэдээлснээр зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2011 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 1.5 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 6.0 хувиар өсчээ⁵.

Хэрэглээний үнийн индекс 2011 оны 10 дугаар сард 100.0 (2010=100) байгаа нь өмнөх сарынхаас 0.1 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 0.2 хувиар буурчээ⁶.

Гадаад худалдааны алдагдал 2011 оны эхний 10 сард 1598.4 тэрбум иен болж, өмнөх оны мөн үеийнхээс 7355.8 тэрбум иенээр өссөн байна⁷.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2011 оны 10 дугаар сард урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх сарынхаас 2.4 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 0.4 хувиар өсчээ.

Ажилгүйдлийн түвшин 2011 оны 10 дугаар сард 4.5 хувь* болж, өмнөх сарынхаас 0.4 пунктээр өсчээ⁹.

Европын холбооны гишүүн орнуудын эдийн засаг

Европын холбооны статистикийн байгууллагын урьдчилсан тооцоогоор (2011 оны 11 дүгээр сарын 15-нд мэдээлснээр) тус холбооны гишүүн 27 орны зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2011 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 0.2 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 1.4 хувиар* өссөн байна.

Инфляцийн түвшин 2011 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 3.4 хувиар нэмэгдсэн байна.

Гадаад худалдааны алдагдал 2011 оны эхний 9 сард 131.8 тэрбум евро болж, өмнөх оны мөн үеийнхээс 10.4 тэрбум евро буюу 8.6 хувиар өсчээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2011 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 2.3 хувиар* буурч, өмнөх оны мөн үеийнхээс 2.3 хувиар өссөн байна.

Ажилгүйдлийн түвшин 2011 оны 10 дугаар сард урьдчилсан гүйцэтгэлээр 9.8 хувь* болж, өмнөх сарынхаас 0.1 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 0.2 пунктээр өсчээ⁹.

ОХУ-ын эдийн засаг

ОХУ-ын Эдийн засаг, хөгжлийн яамны урьдчилсан тооцоогоор зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2011 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеийнхээс 4.3 хувиар өссөн байна¹⁰.

Хэрэглээний үнийн индекс 2011 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 0.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 6.8 хувиар нэмэгджээ.

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны эхний 9 сард 148.3 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 33.0 тэрбум ам.долл буюу 28.6 хувиар нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2011 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 4.0 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 3.6 хувиар өсчээ.

Ажилгүйдлийн түвшин 2011 оны 10 дугаар сард 6.4 хувь болж, өмнөх сарынхаас 0.4 пунктээр өсчээ¹¹.

*-Улирлын нөлөөллийг тооцсон



БНХАУ-ын эдийн засаг

Зураг 1

БНХАУ-ын Үндэсний статистикийн товчооны урьдчилсан тооцоогоор (2011 оны 10 дугаар сарын 21-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2011 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеийнхээс 9.4 хувиар өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс 2011 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 5.5 хувиар өсчээ¹².

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны эхний 10 сард 124.0 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 15.4 хувиар буурчээ¹³.

Харин аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг 2011 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 13.2 хувиар өсчээ¹².

Зэсийн үнэ

Лондонгийн металлын биржид 1 тонн цэвэр зэсийн үнэ 2010 оны 12 дугаар сард дунджаар 9147.26 ам.долл байсан бол 2011 оны 11 дүгээр сард дунджаар 7551.77 ам.долл болж, 1595.49 ам.долл буюу 17.4 хувиар буурсан байна. 1 тонн цэвэр зэсийн үнэ 2011 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 918.11 ам.долл буюу 10.8 хувиар буурчээ¹⁴ (Зураг 1).

Алтны үнэ


Лондонгийн металлын биржид 1 унц алтны үнэ 2010 оны 12 дугаар сард дунджаар 1390.55 ам.долл байсан бол 2011 оны 11 дүгээр сард дунджаар 1738.98 ам.долл болж, 348.42 ам.долл буюу 25.1 хувиар өссөн байна. 1 унц алтны дундаж үнэ 2011 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 369.09 ам.долл буюу 26.9 хувиар өсчээ¹⁵ (Зураг 2).

Газрын тосны үнэ

Нью-Йоркийн худалдааны биржид 1 баррел газрын тосны үнэ 2010 оны 12 дугаар сард дунджаар 89.08 ам.долл байсан бол 2011 оны 11 дүгээр сард дунджаар 97.35 ам.долл болж, 8.27 ам.долл буюу 9.3 хувиар өссөн байна. 1 баррел газрын тосны дундаж үнэ 2011 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 13.25 ам.долл буюу 15.8 хувиар өсчээ¹⁶ (Зураг 3).



Зураг 2



Зураг 3



**Хөрөнгийн биржийн индекс**

АНУ-ын хөрөнгийн биржийн Аж үйлдвэрийн Dow Jones индекс 2011 оны 11 дүгээр сард дунджаар 11804.33 нэгж болж, өмнөх сарынхаас 288.40 нэгж буюу 2.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 606.02 нэгж буюу 5.4 хувиар нэмэгджээ¹⁷.

Токиогийн хөрөнгийн биржийн Nikkei-225 индекс 2011 оны 11 дүгээр сард дунджаар 8506.11 нэгж болж, өмнөх сарынхаас 227.46 нэгж буюу 2.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1291.08 нэгж буюу 13.2 хувиар буурчээ¹⁷.

Лондонгийн хөрөнгийн биржийн FTSE-100 индекс 2011 оны 11 дүгээр сард дунджаар 5402.51 нэгж болж, өмнөх сарынхаас 6.11 нэгж буюу 0.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 331.85 нэгж буюу 5.8 хувиар буурчээ¹⁷.

Эх үүсвэр:

1. <http://bea.gov>
2. <http://stats.bls.gov>
3. <http://www.census.gov/foreign-trade>
4. <http://www.federalreserve.gov>
5. <http://www.esri.cao.go.jp>
6. <http://www.stat.go.jp>
7. <http://www.customs.go.jp>
8. <http://www.meti.go.jp>
9. <http://epp.eurostat.ec.europa.eu>
10. <http://www.economy.gov.ru>
11. <http://www.gks.ru>
12. <http://www.stats.gov.cn>
13. <http://www.mofcom.gov.cn>
14. <http://www.lme.com>
15. <http://www.lbma.org.uk>
16. <http://www.nymex.com>
17. <http://finance.yahoo.com>

ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ИНДЕКС, сараар

НЭГЖ

Он	Аж үйлдвэрийн Dow Jones ¹	Nikkei-225 ²	FTSE-100 ³
2010 I	10067.33	10661.62	5411.65
II	10214.51	10175.13	5231.92
III	10677.52	10671.49	5621.02
IV	11052.15	11139.77	5720.74
V	10500.19	10069.17	5222.87
VI	10159.27	9786.05	5139.44
VII	10222.24	9456.84	5158.39
VIII	10350.40	9268.24	5279.55
IX	10598.07	9346.72	5514.59
X	11044.59	9455.09	5687.18
XI	11198.31	9797.18	5734.36
XII	11465.26	10254.46	5868.38
2010 I-XI	10668.60	10003.66	5467.87
2011 I	11802.37	10449.53	5971.59
II	12190.00	10622.27	6020.97
III	12081.48	9852.45	5856.92
IV	12434.88	9644.63	6007.86
V	12579.99	9650.78	5937.97
VI	12097.31	9541.53	5792.17
VII	12512.33	9996.68	5909.81
VIII	11326.62	9072.94	5271.31
IX	11175.45	8695.42	5228.49
X	11515.93	8733.56	5408.62
XI	11804.33	8506.11	5402.51

Тайлбар:

1. АНУ-ын хөрөнгийн биржийн индекс
2. Токиогийн хөрөнгийн биржийн индекс
3. Лондонгийн хөрөнгийн биржийн индекс

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороонд хэвлэв.

Хаяг :
Засгийн Газрын III байр, Өрөө-113
Улаанбаатар - 20а, Монгол Улс
<http://www.nso.mn>
E-mail: information@nso.mn,
nso@magicnet.mn
Факс: (976-11) 324518
Утас: 322424, 326414